# “ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАМХИГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ БА ТАМХИНЫ ЗАР СУРТАЛЧИЛГАА, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ИВЭЭН ТЭТГЭХИЙГ ХОРИГЛОХ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ”
# ТУРШИЛТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хэрэгжүүлэгч байгууллага: СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

## ТАЛАРХАЛ

“Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх ба тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” туршилт судалгааг Монгол улсад амжилттай гүйцэтгэхэд өөрсдийн туршлага, санал бодлоо бидэнтэй хуваалцаж, үнэтэй зөвлөгөө өгсөн, санхүүгийн дэмжлэг харамгүй үзүүлсэн Монгол улс дахь ДЭМБ-ын суурин төлөөлөгч доктор Сергей Диордица, багийн удирдагч доктор Керстин Шотте, зөвлөх Клем Карлос, зөвлөх Титус Каранжа, ДЭМБ-ын дотоодын зөвлөх Ж.Наранчимэг, ДЭМБ-ын Төв Оффисын мэргэжилтэн Лиззие Тексон, Номхон далайн баруун эргийн бүсийн төвийн мэргэжилтэн Мина Кашивабара болон Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн С.Болормаа нартаа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хамт олноос талархал илэрхийлье.

ДЭМБ-ын хөгжүүлсэн гар утасны Tobacco Spotter аппликейшн ашиглан Монгол Улсын тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтэнд үнэлгээ хийх аргачлалыг турших энэхүү судалгаанд 21 аймаг, 8 дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, НЭМГ, ЭМГ, сэтгэцийн эмч, мэргэжилтнүүд хамтран ажиллалаа.

“Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” сэдэвт туршилт судалгааг Монгол орны цаг агаарын хүнд хэцүү байдлыг үл харгалзан, хамтран ажилласан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага, НЭМЭШСГХ-СТСМТА-ны судлаач нартаа талархал илэрхийлье.

## ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОН

- Эрүүл Мэндийн Яам
- 21 аймаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газар
- 21 аймаг, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,
- 21 аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газар
- 21 аймгийн Нэгдсэн эмнэлэг, сэтгэц-наркологийн тасгийн хамт олон
- Сумдын эрүүл мэндийн төвүүд
- 8 Дүүргийн эрүүл мэндийн төвүүд

### СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ, ЗОХИЦУУЛАГЧ:

В.Баярмаа, Анагаах Ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

### ДЭМБ-ЫН БАГ:

1. Керстин Шотте, багийн ахлагч, ДЭМБ Төв оффис
2. Лиззие Тексон, харилцаа холбооны мэргэжилтэн, ДЭМБ Төв оффис
3. Мина Кашивабара, мэргэжилтэн, ДЭМБ НДБЭБ
4. С.Болормаа, ХБӨ хариуцсан мэргэжилтэн, ДЭМБ Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар
5. Клем Карлос, зөвлөх, ДЭМБ Төв оффис
6. Титус Каранжа, мэдээлэл технологийн зөвлөх, ДЭМБ Төв оффис
7. Ж.Наранчимэг, ДЭМБ-ын дотоодын зөвлөх

**СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:**

1. Б. Жаргал, Анагаах Ухааны доктор (Ph.D), СЭМҮТ
2. Н.Туяа, Анагаах Ухааны магистр, дэд профессор, Ач АУИС
3. К.Елена, Анагаах Ухааны магистр, СЭМҮТ
4. С.Мөнхтуяа, Анагаах Ухааны магистр, СЭМҮТ
5. Е.Гүлжанат, Анагаах Ухааны магистр, СЭМҮТ
6. Б.Батцэцэг, Анагаах Ухааны магистр, СЭМҮТ
7. Т.Мандхай, Анагаах Ухааны магистрант, СЭМҮТ
8. У.Бямбадорж, судлаач-эмч, СЭМҮТ
9. Ж.Гантулга, судлаач-эмч, СЭМҮТ
10. Б.Нацагсүрэн, судлаач-эмч, СЭМҮТ
11. В.Байгалмаа, судлаач, СЭМҮТ
12. П.Энхтуяа, судлаач, СЭМҮТ
13. Г.Мөнхзаяа, судлаач, СЭМҮТ
14. Э.Тамир, судлаач, СЭМҮТ
15. Л.Даваасүрэн, судлаач, СЭМҮТ

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:**

В.Баярмаа, Анагаах Ухааны доктор (Ph.D), СЭМҮТ
С.Мөнхтуяа, Анагаах Ухааны магистр, СЭМҮТ

**АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН:**

Ж.Наранчимэг, Нийгмийн Эрүүл Мэндийн магистр

**ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Л.Насанцэнгэл, Анагаах Ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ

**ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:**

## ГАРЧИГ


**ТАЛАРХАЛ** 2

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ** 5

**ФОТО ЗУРГИЙН ЖАГСААЛТ** 6

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ** 6

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** 6

**ТОВЧ ХУРААНГУЙ** 7

**БҮЛЭГ 1. УДИРТГАЛ** 8

1.1 Судалгааны ажлын үндэслэл 8

1.2 Судалгааны ажлын зорилго 9

1.3 Судалгааны ажлын зорилтууд 9

1.4 Хүлээгдэж буй үр дүн 9

1.5 Судалгааны ажлын ёс зүй 10

**БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ** 11

2.1 Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй 11

2.1.1 Зөвлөх баг, судалгааны ажлын төлөвлөгөө 11

2.1.2 Судалгааны асуумж 11

2.2 Судалгааны загвар 14

2.3 Судалгааны хамрах хүрээ 14

2.4 Мэдээ материал цуглуулсан арга зүй 14

2.5 Судлаач нарыг бэлтгэх сургалт 15

**БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН** 17

3.1 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа 17

3.2 Нийгмийн маркетингийн сурталчилгааны үйл ажиллагаа 23

3.3 Бэрхшээл болон сургамж 27

3.4 Урьдчилсан дүн шинжилгээ, зөвлөмж, нэмэлт тайлан 27

**ХАВСРАЛТУУД** 34

**НОМ ЗҮЙ** 52

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ДЭМБ ТО | ДЭМБ-ын Төв Оффис |
| ДЭМБ СТГ | ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар |
| СЭМҮТ | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв |
| ТЗСДИ | Тамхигүй орчин бүрдүүлэх ба тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох |
| ТТН | Төслийн түүвэрлэлтийн нэгж |
| ТХСК | ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

## ФОТО ЗУРГИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Фото зураг 1 | “Tobacco Spotter” аппликейшний цэс, Монгол хэлээр | 12 |
| Фото зураг 2 | Улаанбаатар хот болон Архангай аймаг дахь сургалт | 15 |
| Фото зураг 3 | Фэйсбүүк сайтууд дээр байршуулсан сурталчилгааны материалууд | 22 |
| Фото зураг 4 | Сугалаа зохион байгуулах үе болон ялагч шалгаруулах үеийн зураг | 23 |
| Фото зураг 5 | Үйл ажиллагааны явцын зураг | 23 |


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Зураг 1 | Монгол улсын засаг захиргааны түвшний бүтэц ба судалгааны нэгжийн сонголт | 13 |
| Зураг 2 | Тамхигүй орчин судалгааны нэгжийн тоо | 17 |
| Зураг 3 | Тамхи худалдаалах цэг-Тамхины зар сурталчилгааны судалгаа | 17 |
| Зураг 4 | Хэвлэл мэдээлэл-Тамхины зар сурталчилгааны судалгаа | 17 |
| Зураг 5 | Кроувдсоурсингийн ирүүлсэн мэдээллийн дүрслэл (2019 оны 2-р сарын 27-оос 4-р сарын 28-ны хооронд) | 18 |
| Зураг 6 | Тамхигүй орчныг кроувдсоурсинг судалгаагаар үнэлсэн байдал | 19 |
| Зураг 7 | Худалдааны цэгүүд дээрх тамхины сурталчилгаа | 20 |
| Зураг 8 | Тамхины сурталчилгааг явуулж буй мэдээллийн хэрэгслийг үнэлсэн судалгаа | 20 |


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Монгол улсад бүртгэлтэй байгууллага, нэгжүүд | 13 |
| Хүснэгт 2 | Оруулсан мэдээллийн хураангуй хүснэгт (уламжлалт болон кроувдсоурсинг) | 19 |
| Хүснэгт 3 | Ирүүлсэн тоог 4-р сарын 30-ны байдлаар аймаг, хотоор харуулав | 20 |
| Хүснэгт 4 | Нийгмийн маркетингийн төлөвлөгөө | 21 |
| Хүснэгт 5 | 4-р сарын 3-18-ны хооронд аймаг, Улаанбаатар хотоос илгээсэн судалгааны явц | 24 |
| Хүснэгт 6 | Туршилтын судалгаанд оролцсон орнуудын товч танилцуулга | 26 |

# ТОВЧ ХУРААНГУЙ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь ДЭМБ-аас санаачилсан тамхины хяналтын тухай хуулийн “Тамхигүй орчин бүрдүүлэх, түүний зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” туршилт судалгааг 2018 оны 9-р сараас 2019 оны 4-р сарын хооронд амжилттай гүйцэтгэсэн.

Энэхүү туршилтын төсөл нь Тамхины хэрэглээний тархалтын дэлхийн тайлангийн нотолгоонд суурилсан мэдээллийн баталгаат байдал ба чанарыг сайжруулах, түүнчлэн тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зөвлөмжийг боловсруулах бөгөөд үүнийг 7 улсад туршиж байна. Эдгээр улсын нэгтгэсэн тайланг 2019 оны 6-р сард орон бүрийн өвөрмөц тайлангийн хамт боловсруулагдан гаргана.

Төслийн гол зорилго нь Монгол улсад тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг туршихад оршино.

Үүний тулд Монгол улс дахь тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэхэд *бэлтгэгдсэн судлаачдад суурилсан ажиглалтын (уламжлалт)* эсвэл *олон нийтэд суурилсан ажиглалтын (кроувдсоурсинг) судалгаа гэсэн 2* аргачлалын аль нь илүү үр дүнтэй байхыг турших зорилгоор ДЭМБ-аас хөгжүүлсэн “Tobacco Spotter” утасны аппликейшн ашиглан үнэлсэн.

Судалгааны багаас ДЭМБ-ын зөвлөх багтай хамтран Улаанбаатар хот ба Архангай аймгийн 80 судлаачдад арга зүйн сургалт явуулж, аппликейшнийг туршсан. Дараагаар нь бэлтгэгдсэн судлаачид түүврийн анхан шатны 75 нэгжид (сум, хороо) байрлах 8 төрлийн 12,677 байгууллагын 3,313 нэгжид ажиглалт хийж, нэгтгэсэн мэдээллээ илгээсэн.

Олон нийтэд суурилсан ажиглалтын судалгааг эхлүүлэхийн өмнө судалгааны баг нь 2019 оны 2-р сараас “Эрхэм инээмсэглэл” маркетингийн компанитай хамтран ухуулга, сурталчилгааны ажлуудыг эхлэн, холбогдох мэдээллийг Tovch News, Mongoldoo.mn Facebook хуудсуудаар тасралтгүй цацсан. Мөн 21 аймагт маркетингийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсний үр дүнд нийт 1,147 хүн 3,954 судалгаа ирүүлсэн нь гайхалтай амжилт байлаа.

Төслийн хүрээнд дээрх хоёр аргачлалын үр дүнтэй бөгөөд үр ашигтай байдлыг харьцуулж үзэхэд: 20 аймаг, Улаанбаатар хотоос 60 экспертийг өргөтгөсөн судалгаанд хамруулж, мэдээллийн санг төвийн зөвлөх багт мөн илгээсэн.

Судалгааны үеэр судалгааны баг нь олон улсын зөвлөх багтай долоо хоног бүр видео уулзалт эсвэл утсаар холбогдон, төслийн хэрэгжилтийн явцыг сайжруулахад хамтран ажилласан.

Туршилт судалгааны үр дүнд уламжлалт буюу бэлтгэгдсэн судлаачдад суурилсан ажиглалтын аргачлал нь өртөг өндөр ч богино хугацаанд үнэн зөв мэдээллийг авах боломжийг олгож байв. Харин уламжлалт аргатай харьцуулахад кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилсан ажиглалтын аргачлал нь идэвхижүүлэх сэдэл бүхий сурталчилгааны ажил, маркетингийн төлөвлөгөө, мониторинг боловсруулах зэрэг ажлуудад тодорхой төсөв, урт хугацаа шаардагдаж байлаа.

# БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

## 1.1 Судалгааны ажлын үндэслэл

ДЭМБ-ын Тамхины хяналтын тухай суурь конвенцийн 8[1], 13[2] дугаар зүйлд дам тамхидалтаас хүмүүсийг хамгаалах, тамхины сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалт байдаг. Эдгээр нь дам тамхидалтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга юм. Тамхины хяналтын тухай Монгол улсын хуульд 2005 онд нэмэлт, өөрчлөлт оруулан, олон нийтийн газар тамхи татах, тамхины сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох тухай заалтуудыг шинэчлэн, 2013 оны 3-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлжээ.

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдсэн 181 гишүүн орон тамхины хэрэглээ, дам тамхидалтаас хамгаалах олон улсын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд асар их хүчин чармайлт гаргаж байгаа ч (ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн хэрэгжилт) дэлхийн хэмжээнд, тэр дундаа манай улсад хуулийн хэрэгжилт, хяналтыг сайжруулах нотолгоонд суурилсан мэдээллийн сантай болох зайлшгүй хэрэгцээ байна. 2007 оноос эхлэн дэлхий даяар тамхигүй орчин бүрдүүлэх, түүний зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглосон хууль эрчимтэй хэрэгжиж байна. 2017 оны байдлаар нийт 1,5 тэрбум хүн амтай 55 улс оронд тамхигүй орчин бүрдүүлэх, 1,1 тэрбум хүн амтай 37 улсад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглосон цогц хууль амжилттай хэрэгжиж байна.

ДЭМБ-аас жил бүр тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилттэй холбоотой мэдээллийг цуглуулж, *ДЭМБ-ын Тамхины хэрэглээний тархалтын дэлхийн тайланд оруулдаг.* Энэхүү тайланд орох мэдээллийг орон бүрийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтан, төрийн бус байгууллагын төлөөлөл, их дээд сургуулийн багш, ажилтан, тамхины хяналтын тухай хөтөлбөр, бодлогын чиглэлээр ажилладаг 3-5 тамхины хяналтын үндэсний шинжээчдийн баг эсвэл тамхины хяналтын үндэсний хөтөлбөр, бодлого хариуцсан ДЭМБ-ын мэргэжилтнээс авдаг. Энэ аргачлалаар, шинжээчид нь тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох тухай хуулийн заалтын хэрэгжилтийг "өндөр", "дунд", "бага" гэж үнэлээд, тоон утганд шилжүүлж дундажийг нь тооцдог бөгөөд тухайн улсын нийслэлд голдуу ажилладаг, цөөн тооны шинжээчдийн мэдээлэлд суурилдаг сул талтай. Цаашид уг аргыг сайжруулахад өөр өөр орон нутгаас илүү олон экспертүүдийг тамхины хууль эрх зүйн хэрэгжилтийг үнэлүүлэхэд оролцуулах болно.

Сүүлийн арван жилд нийгмийн эрүүл мэндийн хувьд кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилан, том бүлгээс нэгэн зэрэг мэдэээллийг цуглуулах боломжтой орчин үеийн судалгааны шинэлэг аргыг нэвтрүүлж эхэлсэн нь зарим талаар үр дүнд хүрээд байна.

Тамхины хэрэглээний талаарх үнэн зөв, харьцуулж болохуйц мэдээлэл цуглуулах болон шинэ технологи ашиглах үүднээс ДЭМБ-аас хоёр шатлалтай туршилтын судалгааг 7 улсад эхлүүлж Чили, Тайландад хэрэгжүүлж байна. Монгол улс нь хоёр дахь шатлалд багтсан билээ.

---

[1] 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:Тамхины утаанд өртөхөөс хамгаалах тухай

[2] 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж: Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох тухай

Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн цаашид техник арга зүй болоод санхүүгийн хувьд хамгийн боломжтой судалгааны аргачлалыг тодорхойлж, тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг үнэлэх загвар гаргах юм.

Түүнчлэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг хуулийн хэрэгжилт, түүнийг эрчимжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, нотолгоонд тулгуурласан тоо баримтаар хангахыг зорьж байгаа юм. Үүнээс гадна, хүчтэй уриалга гаргах, боловсролын хөтөлбөрт тусгах, тамхины хуулийн хэрэгжилт сул байгаа талаар бодлого боловсруулагч, ажилтан, албан хаагчид, олон нийтэд мэдээлэл өгч, хуулийн хэрэгжилтийн түвшин, цаашид ямар арга хэмжээ авбал зохистой талаар (үйлчлүүлэгчдийг дотор тамхи татах хориотой гэдгийг сануулж хэлж байх) ойлголт өгөх, хэрэгжилт муутай хуулийн заалтыг илрүүлэх, хуулинд орсон өөрчлөлтийн ахиц дэвшлийг үнэлэх боломжийг олгодог давуу талтай билээ.

Судалгаа нь 7 улсад (Чили, Монгол, Пакистан, Румын, Тайланд, Уганда, Сэйшелийн арал) хийгдэх бөгөөд эдгээр улсыг нийт хүн амын тоо, газар зүйн тархмал байдал, тамхидалтын тархалт ба тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийн түвшнийг харгалзан сонгосон байна.

## 1.2 Судалгааны ажлын зорилго

Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг турших зорилготой.

## 1.3 Судалгааны ажлын зорилтууд

1. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэх (ТЗДИ) ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтийг уламжлалт аргаар буюу бэлтгэгдсэн судлаач нарт суурилан үнэлүүлэх;
2. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэх (ТЗДИ) ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтийг олон нийтэд суурилан (кроувдсоурсинг) үнэлүүлэх;
3. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх болон ивээн тэтгэх (ТЗДИ) ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх дээрх хоёр аргачлалыг харьцуулах.

## 1.4 Хүлээгдэж буй үр дүн

1. Монгол Улсын Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтэнд үнэлгээ хийгдэж, хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг илрүүлснээр цаашид шийдвэрлэх арга зам тодорхойлогдоно.
2. Тамхины хяналтын тухай хуулийн тамхи татахыг хориглох, тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтийг уламжлалт ба кроувдсоурсинг (гар утасны аппликейшн ашиглах) аргачлалаар судалсны үндсэн дээр цаашид тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжтой арга, аргачлалыг тодорхойлно.

## Судалгааны ажлын ёс зүй

Судалгааны ажлыг эхлэхээс өмнө 2018 оны 9-р сарын 12-ны өдөр Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Эрдэм шинжилгээний хорооны хурлын N18/06-р хурлаар судалгааны арга зүйг батлуулсан. Дараа нь аргачлалыг ЭМЯ-ны Ёс зүйн салбарын хорооны хурлаар хэлэлцүүлж, ёс зүйн зөвшөөрөл авсан.

**АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр | №81 | 210648 Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж-2,
Засгийн газрын VIII байр,
Эрүүл мэндийн яам
Утас 261845, Факс:323541

Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монгол улс дахь тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх туршилт судалгаа" сэдэвт судалгааны ажлыг судлаач АУ-ны доктор дэд профессор Л.Насанцэнгэл нарын удирдлаган дор 2018-2020 онд багтаан хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Судалгааны явцад тодорхой шалтгааны улмаас арга аргачлалд өөрчлөгдөх, гадаад орон луу сорьц тээвэрлэх, Хельсинкийн тунхаглалд туссан ёс зүйн асуудал хөндөгдсөн тохиолдолд анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэж, дахин хэлэлцүүлэхийг судалгааны багийнханд үүрэг болгосугай.
3. Судалгааны явцын болон төгсгөлийн тайланг эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.
4. Судалгааны төгсгөлийн тайланг судалгаа дууссан хугацаанаас хойш 2 сарын дотор багтаан анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.

ДАРГА Д.ОЮУНЧИМЭГ

1118270972 ... 087443

# БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ

## 2.1 Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгааны гол зарчим бол Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх ба тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг туршихдаа ДЭМБ-аас боловсруулсан мэдээлэл цуглуулах программыг www.tobacco spotter.com сайтаас татан авч, судалгааг нэг дор бөглөн илгээх байв.

### 2.1.1 Зөвлөх баг, судалгааны ажлын төлөвлөгөө

Судалгааны баг нь зөвлөх багтай харилцан зөвлөж, судалгааны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан (Хавсралт 1). Судлаачдын багт СЭМҮТ-ийн 15 судлаач, орон нутгийн 40 судлаач орсон. Судалгааны зохицуулагч нь бүх судалгааны ажил цаг хугацаандаа, зохих стандартын дагуу явагдаж байгаа эсэх ДЭМБ-ын төв оффис, бүсийн баг, орон нутгийн зөвлөхтэй нягт хамтран ажиллах бас судалгаа эхлэхээс өмнө судлаачдыг шаардлагатай бүх материалаар хангах, мэдээлэл цуглуулахаас өмнө сургалтанд хамруулах үүрэгтэй бөгөөд ажиглалт хийх явцад ямар нэгэн бэрхшээл гарахад туслалцаа үзүүлнэ. Гэрээний дагуу, тухайн улсын хэрэгжүүлэгч байгууллага нь үндэсний хэмжээнд мэдээллийг цуглуулах үүрэгтэй. Хүлээн авсан мэдээллийг программын хяналтын самбар дээрээс цаг алдалгүй харах боломжтой бөгөөд тэдгээрийн чанар, алдаа зэргийг байнга шалгана.

Мэдээллийг Эрүүл мэндийн яам болон ДЭМБ өмчлөх бөгөөд үр дүнг туршилтын бусад орны үр дүнтэй харьцуулах, тайланд болон хэвлэн нийтлэхэд ашиглах зорилгоор мэдээллийн санд нэвтрэх эрхтэй. Энэ талаар хэрэгжүүлэгч байгуулагатай хийсэн гэрээнд тусгасан (Хавсралт 2: Мэдээлэл солилцох гэрээ).

### 2.1.2 Судалгааны асуумж

Судалгаанд гурван төрлийн аппликейшн ашигласан. Мэдээлэл цуглуулах ажил нь эхлээд гарын авлага, заавар, судалгааны асуултуудыг Англиас Монгол хэлнээ орчуулж, дараа нь гадны орчуулагчаар Монголоос Англи руу эргүүлэн орчуулах алхмуудын дагуу явагдаж, судалгааны асуулт бүрийн утга, ойлголтыг монгол агуулгад нийцүүлэн баталсан.

1. Дотоод орчинд тамхи татахыг бүрэн хориглосон байгууллагаас авах судалгааны карт: ДЭМБ-ын тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг үнэлэх стандарт асуумж бөгөөд эхний хэсэгт судалгаанд хамрагдсан байгууллагын байршил, үйл ажиллагааны чиглэлийг тодруулах зорилго бүхий 11 асуулт, дараагийн хэсэгт байгууллагын дотоод орчинд ажиглалт хийж тэмдэглэх 14 асуултаас бүрдэнэ (Хавсралт 3).
2. Дотоод орчинд тамхи татахыг бүрэн хориглосон боловч зарим газар (тамхи татах өрөө) тамхи татахыг зөвшөөрсөн байгууллагаас авах судалгааны карт: ДЭМБ-ын тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг үнэлэх стандарт асуумж бөгөөд эхний хэсэгт судалгаанд хамрагдсан байгууллагын байршил, үйл ажиллагааны чиглэлийг тодруулах зорилго бүхий 11 асуулт, дараагийн хэсэгт байгууллагын дотоод орчинд ажиглалт хийж тэмдэглэх 14 асуултаас бүрдэнэ (Хавсралт 3).

3. Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг ажиглах судалгааны карт: ДЭМБ-ын тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг үнэлэх стандарт асуумж бөгөөд тамхины худалдаа, гадаад орчин дахь тамхины сурталчилгаа, ажиглах болон тамхины сав, баглаа боодлыг ажиглахаар нийт 3 бүлэг бүхий 21 асуултаас бүрдэнэ (Хавсралт 3):
    - Тамхины зар сурталчилгааг ажиглах асуулт;
    - Гадаад орчны зар сурталчилгааг ажиглах асуулт; ба
    - Тамхины сав баглаа боодлыг ажиглах асуулт.

Судлаачид ДЭМБ-аас боловсруулсан Android, IOS үйлдлийн систем бүхий гар утас, таблет төхөөрөмжид Tobacco Spotter (Тамхи илрүүлэгч-асуумж) зориулалтын аппликейшнийг PlayStore-с үнэгүй татан авч, интернет орчинд байршлаа идэвхжүүлэн, Монгол хэлэнд хөрвүүлсэн зааврын дагуу тохиргоог хийсэн. Аппликейшнийг ашиглан дараах байршилд үнэлгээг хийсэн. Үүнд:

I. Ангиллын дагуух нэгжүүд:
    а. Эрүүл мэндийн байгууллага/Эрүүл мэндийн төв
    б. Бага/дунд сургууль
    в. Их сургууль/коллежууд
    г. Төрийн байгууллагууд
    д. Хувийн байгууллагууд
    е. Ресторан
    ё. Кафе, паб/баар
    ж. Нийтийн тээвэр
    з. Бусад

II. Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийг тамхи худалдаалах цэг, зарлалын самбар зэрэгт ажиглах

III. Хэвлэл мэдээллээр тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийг ажиглах

Судалгааны асуумж нь хурдан хугацаанд, хаана ч ашиглах боломж бүхий хялбар аргаар бэлтгэгдсэн, “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариултаар бөглөгдөх 5-10 асуулттай 5-10 секунд зарцуулагдана. Tobbacco Spotter Аппликейшн нь Оффлайн (сүлжээгүй, интернет сүлжээнд холбогдоогүй, датагүй) нөхцөлд ч ажиллах гар утасны (location information) байршил заагчийн тусламжтайгаар судалгааг бөглөх газрыг тэмдэглэн оруулж өгсөн. Үндсэн тохиргоо руу нэвтрэхдээ судлаачид өөрсдийн нэвтрэх ID болон нууц кодоор судалгааны аппликейшнд нэвтэрч байсан бол олон нийтэд ID болон нууц код өгөөгүй болно (Хавсралт 4, 5).

**Аппликейшн цэсийг зургаар харуулахад:**

**Фото зураг 1. “Tobacco Spotter” аппликейшний цэс, Монгол хэлээр**



## 2.2 Судалгааны загвар

Ажиглалт, нэг-агшингийн судалгааны аргаар түүврийг сонгохдоо хоёр шатлалт кластр түүвэрлэлтийн аргыг ашигласан. Эхний шатанд хүн амын тооноос хамаарч судалгаа явуулах газрыг, хоёр дахь шатанд газар зүйн онцлогоос шалтгаалан байгууллагыг тус тус сонгосон. Судалгааны өмнө түүвэрлэлтийн анхдагч нэгжээс байгууллага тус бүрийн төрлөөс хангалттай сонгож мөн судлаачдад мэдээлэл цуглуулах үйл явцыг цэгцлэн хэт том биш жагсаалтаас Excel программын тусламжтайгаар санамсаргүй түүвэрлэлтийн аргаар судалгаанд хамруулах байгууллагыг сонгосон.

## 2.3 Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд хоёр-шатлалт санамсаргүй түүврийн арга ашиглан 21 аймгийн төв, сумд ба Улаанбаатар хотын 9 дүүргийн хорооноос судалгааны нэгжүүдийг сонгосон.

**Зураг 1. Монгол улсын засаг захиргааны түвшний бүтэц ба судалгааны нэгжийн сонголт**




**Хүснэгт 1. Монгол улсад бүртгэлтэй байгууллага, нэгжүүд**

| **Улсын хэмжээний нийт тоо** | | **Улаанбаатар хотоос гадна** | |
|---|---|---|---|
| Их, дээд сургууль, коллеж, МСҮТ | 469 | Хүнсний дэлгүүр | 4173 |
| Эмнэлэг, эрүүл мэндийн төв | 1203 | Зах | 22 |
| Ерөнхий боловсролын сургууль | 1439 | Түргэн үйлчилгээний цэг | 464 |
| Төрийн байгууллага | 2273 | Улсын үйлдвэр | 112 |
| Хувийн хэвшлийн байгууллага | 4967 | Бөөний худалдааны төв | 45 |
| Ресторан | 2614 | Баар цэнгээний газар, шөнийн клуб | 198 |
| Кафе, баар, паб | 2249 | Караоке | 424 |
| Тамхи худалдаалах цэг | 2594 | Автобусны эцсийн зогсоол, галт тэрэгний зогсоол, автобус бааз | 71 |
| Нийт 17,808 нэгжид үүнээс 4,000 нь төрийн байгууллага; 56,400 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж; 798 нь бага /дунд/ ахлах сургууль; 1,894 нь улсын болон хувийн эмнэлэг; 350 нь сүм хийд/сүм; 3,900 нь зочид буудал, хоолны газар байв. | | | |

## 2.4 Мэдээ материал цуглуулсан арга зүй

Судалгааны баг нь санамсаргүй түүврийн аргаар тухайн газарт байгаа түүврийн нэгжийн 4 төрлөөс (эмнэлэг, ЕБС, их дээд сургууль, төрийн байгууллага) 12 нэгжийг сонгон, үлдсэн 4 нэгж (хувийн хэвшлийн байгууллага, баар/кафе, ресторан, нийтийн тээвэр)-ийг нэмэх товчийг ашиглан сонгоод мэдээллийг цуглуулж авсан.

“Дотоод орчинд тамхигүй орчин бүрдүүлэх заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ судалгааг дараах нэгж, газруудаас түүвэрлэн авлаа. Үүнд:

а. Эрүүл мэндийн байгууллага (төрөлжсөн мэргэжлийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эмнэлэг/олон нийтийн болон хувийн эрүүл мэндийн байгууллага);

б. Боловсролын байгууллага (улсын болон хувийн бага, дунд, ахлах сургууль);

в. Их дээд сургууль (коллеж, МСҮТ, улсын болон хувийн их дээд сургууль);

г. Төрийн байгууллага (төр захиргааны байгууллагын үйл ажиллагаа явуулдаг барилга/байр/сууц);

д. Дотоод орчин (ТББ, банк, шуудан, жижиглэн худалдаа, худалдааны төв, супермаркет, дэлгүүр);

е. Ресторан (хоол үйлдвэрлэл, үйлчилгээн дээр тогтож буй бизнес);

ё. Кафе, паб, бар (архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг газрууд);

з. Нийтийн тээвэр (такси, галт тэрэг, автобус);

ж. Бусад (шашны байгууллага, зочид буудал, хорих газар, хүнсний дэлгүүр гэх мэт).

“Тамхины зар сурталчилгаа, ивээн тэтгэхийг хориглосон заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ доорх зар сурталчилгааны дараах сувгуудыг хамруулсан. Үүнд:

а. Худалдааны цэгүүд

б. Зар сурталчилгааны самбар

в. Радио

г. Телевиз

д. Сонин сэтгүүлүүд

Нэгдүгээр шатанд Монгол улсын 21 аймгийн нийт 330 сумаас 39 сумыг, Улаанбаатар хотын 152 хорооноос 34 хороог санамсаргүй түүврийн аргаар сонгож, анхдагч түүврийн нэгж нь 75 байхаар тооцон, судалгааны сургалтанд хамрагдсан бэлтгэгдсэн судлаачид мэдээллийг цуглуулсан. Гар утасны программын тусгай нэвтрэх код ашиглан 8 төрлийн газар, худалдааны цэг, мэдээллийн хэрэгслийг ажиглах 3 бүлэг судалгааг бөглөж 2,500 гаруй нэгжийг хамруулсан.

Дараагийн шатанд, сонгогдсон 75 нэгжид (сум, хороо) орших 8 төрлийн 12,677 байгууллагаас нийт 2,800 орчим байгууллагыг санамсаргүй байдлаар сонгосон. Судлаачид Тамхины хяналтын тухай хуулийн утаат тамхи татахыг хориглох, тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох заалтын хэрэгжилтэд ажиглалтын судалгаа хийсэн.

## 2.5 Судлаач нарыг бэлтгэх сургалт

Уламжлалт буюу бэлтгэгдсэн судлаачдад суурилсан судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2018 оны 11-12-р сард, кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилсан судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2019 оны 2-4-р сарын хугацаанд тус тус хийхээр товлосон.

Судлаач бэлтгэх сургалтыг хоёр үе шаттайгаар Улаанбаатар, Архангай аймагт зохион байгуулсан (Хавсралт 6).

Улаанбаатар хотын судлаач бэлтгэх сургалтыг 2018 оны 9-р сарын 26-29-ний өдрийг дуустал 3 хоног Континентал зочид буудлын сургалтын танхимд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Дүүргүүдийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газрын мэргэжилтэн, Засаг даргын тамгын газрын мэргэжилтнүүд зэрэг 40 судлаачдын дунд хийсэн. Сургалтын гурав дахь өдөр оролцогчид уг программыг ашиглан туршилт хийсэн бөгөөд судлаачдын баг,

сургагч багш нар тулгарсан бэрхшээл, мэдээлэл цуглуулах болон тэмдэглэл хөтлөх нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн.

Орон нутгийн судлаач бэлтгэх 3 хоногийн сургалтыг 2018 оны 9-р сарын 28-30-ны өдрийг дуустал Архангай аймгийн Эрүүл мэндийн газар зохион байгуулсан. Сургалтанд Архангай, Баян-Өлгий, Хэнтий, Сэлэнгэ, Баянхонгор, Ховд, Дархан-Уул, Дорнод зэрэг 8 аймгийн 40 судлаач хамрагдсан бөгөөд ДЭМБ-ын Dr Clem Carlos зөвлөх, Mr Titus Karanja зөвлөх, Dr Kerstin Schotte, Ms Lizzie tecson, Ms Mina Kashiwabara болон Монгол дахь ДЭМБ-ын мэргэжилтэн Ж.Наранчимэг болон судалгааны багийн гишүүд оролцсон.

**Фото зураг 2. Улаанбаатар хот болон Архангай аймаг дахь сургалт**




## БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

### 3.1 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа

***Бэлтгэгдсэн судлаачдад суурилсан ажиглалтын (уламжлалт) судалгаа***

Судалгааны баг ДЭМБ-ын зөвлөхүүдтэй хамтран гар утасны асуумжийг тохируулан сайжруулж 2018 оны 11-р сард дууссан.

Гар утасны аппликейшн бүхий судалгааны асуумж нь 3 хэсгээс бүрдсэн:

1. Нийтийн эзэмшлийн 8 төрлийн байгууллага дээр (эмнэлэг, ЕБС, их дээд сургууль, төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, ресторан, кафе/баар, нийтийн тээвэр) тамхигүй- дотоод орчны судалгаа;
2. Тамхи худалдаалах цэгийн судалгаа (ТҮЦ, хүнсний дэлгүүр, супермаркет, тамхины бөөний төвүүдээс);
3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж буй сурталчилгааны судалгаа (ТВ, радио, сонин, сэтгүүлээс).

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн судлаачид 2, 2-оор нийт 6 багаар 2018 оны 12-р сард бүх 21 аймгийг баруун, зүүн, хангай, төвийн бүсээс сонгогдсон 39 сумаас мэдээлэл цуглуулахаар 14-30 хоногийн туршид ажилласан. Тухайн орон нутгийн ЗДТГ, МХГ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, сэтгэц-наркологийн эмч нарыг судалгааны багт хамруулан 5 хүнтэйгээр үргэлжлүүлэн ажилласан.

**Үндсэн баг дараах 7 чиглэлээр ажилласан. Үүнд:**

**Чиглэл 1:** Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Цэцэрлэг сум, Хайрхан сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Улиастай сум, Увс аймгийн Зүүнхангай сум, Улаангом сум зэрэг газруудын 480 нэгжид СЭМҮТ болон орон нутгаас хамтран багаар ажиллан судалгааг явуулсан. Багийн ахлагчаар В.Баярмаа, багийн гишүүдээр Ж.Гантулга, Н.Туяа, Ариун-Эрдэнэ, М.Үржинханд, Минжилмаа нар ажилласан.
**Чиглэл 2:** Баян-Өлгий аймгийн Өлгий сум, Улаан хус сум, Булган сум, Ховд аймаг, Ховд аймгийн Цэцэг сум, Говь-Алтай аймгийн Алтай сум, Дэлгэр сум, Гуулин тосгон, Баянхонгор аймгийн Цагаан овоо, Баян овоо сум, Өвөрхангай аймаг, Өвөрхангай аймгийн Сант, Хайрхандулаан, Лүн сум зэрэг 11 газрын 770 нэгжид СЭМҮТ болон орон нутгаас хамтран багаар ажиллан судалгааг явуулсан.
Баян-Өлгий аймгийн Булган сум дахь даваанууд цасанд боогдож очих боломжгүй байсан тул ДЭМБ-ын зөвшөөрлөөр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас судалгаагаа авсан. Зарим аймгаас сум руу явахад анх төлөвлөгдсөнөөс зам хол, бартаа ихтэй, шороо, чулуу, даваа ихтэй байлаа. Судалгааг С.Мөнхтуяа ахлагчтай В.Байгалмаа, С.Досбол, Хосбаяр, Лусолмаа, Оюунтунгалаг, Аманбол, Еркебулан, Цэцэгмаа, Нарантуяа, Оюунбат, Юмжирмаа, Мариа нар явуулсан.
**Чиглэл 3:** Сэлэнгэ аймгийн Мандал сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Булган аймгийн Баян-Агт сум, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Хөвсгөл аймгийн Рашаант сум зэрэг газруудын 475 нэгжид СЭМҮТ болон орон нутгаас хамтран багаар ажиллан судалгааг явуулсан. Багийн ахлагчаар У.Бямбадорж, багийн гишүүдээр Б.Нацагсүрэн, Э.Тамир нар ажилласан.
**Чиглэл 4:** Говь-Сүмбэр аймгийн Сүмбэр сум, Дундговь аймгийн Говь-Угтаал сум, Дорноговь аймгийн Сайншанд сум, Хатанбулаг сум, Даланжаргалан сум, Төв аймгийн Баянжаргалан сум зэрэг газруудын 377 нэгжид СЭМҮТ болон орон нутгаас хамтран багаар ажиллан судалгааг явуулсан. Багийн ахлагчаар Е.Гүлжанат, П.Энхтуяа, Гэрэлмаа нар багийн гишүүдээр ажилласан.
**Чиглэл 5:** Өмнөговь аймгийн Баяндалай сумын 23 нэгжид СЭМҮТ болон орон нутгийн баг хамтран ажиллаж судалгааг явуулсан. Багийн ахлагчаар Б.Батцэцэг, багийн гишүүнээр Г.Мөнхзаяа нар ажилласан.
**Чиглэл 6:** Хэнтий аймгийн Жаргалтхаан, Баян Овоо сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Уулбаян сум, Дорнод аймгийн Чойбалсан хот, Халх гол сум, Улаанбаатар хотын Багануур дүүргийн 5–р хороо, Налайх дүүргийн 3–р хорооны нутаг дэвсгэрт нийт 7 нэгжид орон нутгийн сургагдсан судлаач нарын багийнхантай хамтран СЭМҮТ–ийн мэргэжилтэн Т.Мандхай ахлагчтай СЭМҮТ-ийн нийгмийн ажилтан Л.Даваасүрэн нар судалгааг амжилттай явуулсан.
**Чиглэл 7:** Дархан-Уул аймгийн төв, Орхон сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум зэрэг газруудын 258 нэгжид СЭМҮТ болон орон нутгийн баг хамтран ажиллаж судалгааг явуулсан. Багийн ахлагчаар У.Бямбадорж, багийн гишүүдээр Б.Нацагсүрэн, Э.Тамир нар ажилласан.
Судалгааны баг 2019 оны 1-р сард Улаанбаатар хотын 54 хорооноос судалгаагаа үргэлжлүүлэн авсан. Улаанбаатарт нийтдээ хянах самбарын дүнгээр 1,000 орчим мэдээллийг цуглуулсан.

Хяналтын самбарт нийт 3,513 нэгжийн мэдээлэл орсон бөгөөд 3 бүлэг болгон авч үзэхэд нийт 810 эмнэлэг, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, төрийн байгууллага,

хувийн хэвшлийн байгууллага, ресторан, кафе/бар, нийтийн тээвэрт 2,663 судалгаа бүртгэгдсэн.

**Зураг 2. Тамхигүй орчин судалгааны нэгжийн тоо**




Нийт 194 түргэн үйлчилгээний цэг, хүнсний дэлгүүр, супермаркет, тамхины бөөний худалдааны төв, тамхи худалдаалах цэгт нийт 553 ажиглалт хийв.

**Зураг 3. Тамхи худалдаалах цэг-Тамхины зар сурталчилгааны судалгаа**




Телевиз, радио, сонин, сэтгүүлээр дамжуулан сурталчилгааны ажилд 307 ажиглалт хийв.




***Олон нийтэд суурилсан ажиглалтын (кроувдсоурсинг) судалгаа***

"Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилсан судалгаа нь 2019 оны 2-4-р сар хүртэл үргэлжилсэн. Гар утасны уг программ нь асуулга бөглөхөд нэвтрэх код буюу нууц үг шаардахгүй бөгөөд зөвхөн нас, хүйс оруулна. 4-р сарын 28-ны байдлаар нийт 1,147 хүн 3,953 судалгааг илгээсэн (Зураг 5) нь таамаглаж байгаагүй үр дүн байлаа. Дунджаар нэг хэрэглэгч 3-4 судалгаа бөглөсөн байна.

**Зураг 5. Кроувдсоурсингийн ирүүлсэн мэдээллийн дүрслэл (2019 оны 2-р сарын 27-оос 4-р сарын 28-ны хооронд)**




Хяналтын самбараас харахад, 18-94 насны хүмүүс (ахмад настнуудын 2 тохиолдол бүртгэгдсэн: 94, 72 настай) судалгаанд оролцсон бөгөөд 26-35 насныхан 50 хувь, 18-25 насныхан 22 хувь, 36-45 насны хүмүүс 19 хувийг эзэлж байсан нь сонирхолтой байв. Дунд болон ахмад настнуудын оролцоо бага (ердөө 10 хувь) байв. Хүйсийн хувьд, эмэгтэйчүүд бараг 70 хувийг эзэлж байв. Ерөнхийдөө идэвхитэй гар утасны хэрэглэгчид болох залуу, ажиллаж буй хүмүүс гол оролцогчид байлаа. Нийт судалгааны 25 хувийг Улаанбаатар хотоос бөглөсөн байсан нь нийгмийн сүлжээ нь мэдээллийн чухал эх үүсвэр болсны тод илрэл гэж хэлж болохоор байв.

Гурван бүлэглэлээр ирүүлсэн судалгааны 76 хувь нь тамхигүй орчинд, 8 хувь нь тамхи худалдаалах цэгийн сурталчилгаанд, 16 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн тамхины сурталчилгааны талаар хяналт тавьж ажигласан байв (Хүснэгт 2).

**Хүснэгт 2. Оруулсан мэдээллийн хураангуй хүснэгт (уламжлалт болон кроувдсоурсинг)**

| Хэлбэр | Уламжлалт (54 судлаач) | Кроувдсоурсинг (1147 оршин суугчид) | Нийт |
|---|---|---|---|
| Тамхигүй орчны судалгаа | 2664 | 2986 | 5650 |
| Тамхи худалдаалах цэгийн сурталчилгааны судалгаа | 543 | 331 | 874 |
| Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тамхи сурталчилах | 307 | 636 | 943 |
| Нийт | 3514 | 3953 | 7467 |

Тамхигүй орчныг үнэлсэн судалгааны мэдээллийн 22 хувь нь эрүүл мэндийн, 21 хувь нь төрийн албаны, 15 хувь нь хувийн хэвшлийн байгууллагууд тус тус, 12 хувь нь ерөнхий боловсролын сургуулийг, 8 хувь нь нийтийн тээврийг, 7 хувь нь бусад газрыг, 6 хувь нь их сургууль, коллеж, МСҮТ-ийг, 5 хувь нь ресторан, 3 хувь нь кафе, баар, паб-ыг үнэлжээ (Зураг 6).

**Зураг 6. Тамхигүй орчныг кроувдсоурсинг судалгаагаар үнэлсэн байдал**




Худалдааны цэгүүд дээрх тамхины сурталчилгааг ажиглах судалгаанд ТҮЦ, супермаркет, хүнсний дэлгүүр, бөөний цэгүүд болон бусад газрууд хамрагдсан байна. Судалгаанд супермаркет (30 хувь орчим), хүнсний дэлгүүр (26 хувь) болон бусад (23 хувь) хамрагдсан. ТҮЦ, бөөний цэгүүдийн 22 хувьд (ажиглалтаар) тамхины жижиглэнгийн худалдаа тогтмол явагдаж байгааг харуулсан (Зураг 7).




Судалгаанд оролцогчид 636 сэтгүүл, сонин, радио, телевизээр явж буй тамхины сурталчилгааг ажигласан. Ихэнх хүмүүс сурталчилгааны самбар (48 орчим хувь), телевизийн нэвтрүүлгийг (31 хувь) бусад хэрэгслүүд/сувгуудтай харьцуулахад илүү үнэлсэн байна (Зураг 8).




Оруулсан мэдээллийн түвшин нь аймгуудад 3-аас 471 хооронд хэлбэлзэж байсан (Хүснэгт 3). Ерөнхийдөө, аймгуудаас илгээсэн судалгааны дундаж тоо 119 байв. Аймгуудтай харьцуулахад Улаанбаатар хотоос 752 гаруй хүн ирүүлсэн, аймгуудын дундаас 9 аймаг 115-аас 470, 9 аймаг 100-аас бага, 3 аймаг нь 10-аас бага судалгааг илгээсэн байв.

**Хүснэгт 3. Ирүүлсэн тоог 4-р сарын 30-ны байдлаар аймаг, хотоор харуулав**

| **Аймаг /Хот** | Улаанбаатар | Булган | Говь-Алтай | Баян-Өлгий | Төв | Хөвсгөл | Дорноговь | Дархан-Уул | Дорнод | Ховд | Орхон | Баянхонгор | Өвөрхангай | Дундговь | Говьсүмбэр | Увс | Завхан | Сүхбаатар | Архангай | Сэлэнгэ | Хэнтий | Өмнөговь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт тоо** | 752 | 471 | 343 | 303 | 290 | 188 | 159 | 158 | 141 | 115 | 54 | 43 | 43 | 37 | 36 | 35 | 29 | 18 | 14 | 9 | 6 | 3 |

### 3.2 Нийгмийн маркетингийн сурталчилгааны үйл ажиллагаа

Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх ба тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх гар утасны программыг олон нийтэд сурталчлах зорилгоор хоёр сарын хугацаатай "Нийгмийн маркетингийн төлөвлөгөө" боловсруулж, 2019 оны 2-р сарын 19-ээс 4-р сарын 30-ны хооронд "Эрхэм инээмсэглэл" маркетингийн компанитай хамтран хэрэгжүүлсэн (Хавсралт 7).

ДЭМБ-ын боловсруулсан аргачлалын дагуу төлөвлөгөө нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, хүрч очих үйл ажиллагаа зэрэг стратегиудтай байсан. Түүнчлэн төлөвлөгөөнд “17 Factory онлайн пүүз”-худалдааны сайтаар дамжуулан сугалаа зохион байгуулах, 21 аймагт орон нутгийн кампанит ажил зохион байгуулах нэмэлт стратегиудыг тусгасан болно.

**Хүснэгт 4. Нийгмийн маркетингийн төлөвлөгөө**

| **Сар** | **2-р сар** | **3-р сар** | | | | **4-р сар** | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 хоног | 4-р | 1-р | 2-р | 3-р | 4-р | 1-р | 2-р | 3-р | 4-р |
| ХЭРЭГСЭЛ | | | | | | | | | |
| Төлөвлөгөө А: Facebook/фэйсбүүк хуудсанд мэдээллээ байршуулах | | 3-р сарын 3: Телевизийн реклам, зурагт хуудас, танилцуулга (Facebook: Tovch News; Mongoldoo.mn; 17 Factory) | | | | | | | |
| Төлөвлөгөө В: Мэдээллийн хэрэгсэл (телевизийн ярилцлага, бичлэг хийх) | | 3-р сарын 6: МҮОНТ | 3-р сарын 12: Бичлэг | | | | | | |
| Төлөвлөгөө С: Бүүст хийх | Бүүст 1 | | | | | | | | |
| Төлөвлөгөө D: Улаанбаатарт явуулах үйл ажиллагаа (товч танилцуулга, сургалт) | | 3-р сарын 11: СЭМҮТ | 3-р сарын 13: ULI | | 3-р сарын 26: ЭМЯ | | | | |
| ДЭЛГЭРЭНГҮЙ | | | | | | | | | |
| Төлөвлөгөө E: 17 Factory онлайн дэлгүүртэй хамтран сугалаа зохион байгуулах | | 3-р сарын 5-18 | | | | | | | |
| Төлөвлөгөө F: 21 аймагт үйл ажиллагаа зохион байгуулах (сурталчилгааны материал хүргүүлэх) | | | 3-р сарын 15-4-р сарын 25 | | | | | | |
| Төлөвлөгөө L: Tovch News сайтаар дамжуулан мэдээлэл тараах | | | 3-р сарын 19-4-р сарын 25 | | | | | | |

СЭМҮТ-ийн баг 21 аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн хэмжээнд олон нийтэд суурилсан сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлэх албан бичиг хүргүүлж, халдварт бус өвчин хариуцсан мэргэжилтэн нь орон нутгийг хариуцсан төлөвлөгөөний зохицуулагчийн үүрэг гүйцэтгэн ажиллалаа. Орон нутгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор аймаг бүрт 200,000 төгрөгийг олгосон. Орон нутгийн 21 зохицуулагчийн 5 нь уламжлалт судалгаанд оролцсон бэлтгэгдсэн судлаачид байв.
Судалгаанд хамрагдахаас өмнө зурагт хуудас, мэдээлэл, гарын авлага, 3 сурталчилгааны видеог багтаасан сурталчилгааны материалыг цогц байдлаар боловсруулж, хоёр долоо хоногийн турш Фэйсбүүкийн "TovchNews" (https://www.facebook.com/TovchMN/видео/435983513816279/) болон "Mongoldoo.mn" нь сайтууд дээр байршуулсан. Энэ сайтууд нь маркетингийн компанийн түнш бөгөөд 52,000 хэрэглэгч дагалддаг, эдгээр сайтуудад материалыг үргэлжлүүлэн байршуулсан (Фото зураг 3).

**Фото зураг 3. Фэйсбүүк сайтууд дээр байршуулсан сурталчилгааны материалууд**




Аймаг бүр маркетингийн төлөвлөгөө боловсруулж, 2019 оны 3-р сарын дунд үеэс эхлэн хэрэгжүүлсэн. Хорин нэгэн аймгийн Эрүүл мэндийн төв, ЗДТГ, орон нутгийн мэдээллийн Фэйсбүүк хуудаснаа дээрх материал, видеог байршуулсан.

Олон нийтийн сонирхлыг өдөөх зорилгоор 2019 оны 3-р сарын 5-наас 18-ны хооронд “17 Factory”онлайн пүүз” худалдааны сайттай хамтран анхны сугалаа зохион байгуулагдлаа. Сугалаанд 150 гаруй хүн оролцсон. Энэ нь идэвхжүүлэх үйл ажиллагааны үр дүнтэй эхлэл байсан юм. Бид Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр (3-р сарын 8), Монгол цэргийн өдөр (3-р сарын 18) гэх мэт тодорхой өдрүүдийг ашиглан хоёр удаа зохион байгуулахаар төлөвлөж байсан ч оролцогчдын тоо хангалтгүй байсан учраас бид товлосон өдрийг хоёр долоо хоногоор сунгасан.

**Фото зураг 4. Сугалаа зохион байгуулах үе болон ялагч шалгаруулах үеийн зураг**






**Фото зураг 5: Үйл ажиллагааны явц**



Кампанит ажлуудыг 21 аймагт хэрэгжүүлэх явцад аймаг бүрт мэдээлэл ирүүлсэн тоог харуулсан хяналтын хуудсыг боловсруулсан. TovchNews сайтад хяналтын хуудсыг байрлуулж, 21 аймгийн зохицуулагч нартай тогтмол хуваалцсан. Энэ нь тэдэнд судалгааны үр дүнг үнэлж, шаардлагатай арга хэмжээг авахад нь тустай байв. Үүний зэрэгцээ бид тэднийг өөрсдийн туршлагаа өөр аймаг дахь бусад зохицуулагч нартаа хуваалцахыг уриалж байв.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас болж аймаг бүр дор хаяж 100-150 судалгааг ирүүлэх шаардлагыг тавьсан. Гэтэл уг тогтоосон хэмжээнд хүрсэн аймгуудын үйл ажиллагаа саарч эхэлсэн нь ажиглагдсан. Жишээлбэл: Төв, Ховд аймгууд дөрөвдүгээр сарын эхний долоо хоногт зорилтот түвшинд хүрсэн тул цаашдаа бараг зогсонги болсон. Говь-Алтай, Дорнод, Баянхонгор, Хөвсгөл, Булган зэрэг зарим аймгуудын тоо аажмаар нэмэгдсээр байсан. Баян-Өлгий зэрэг цөөн аймгууд олон нийтийн байгууллагуудыг судалгаанд хамруулах зэргээр бусад аймгийн үзүүлэлтийг богино хугацаанд давсан байна.

**Хүснэгт 5. 4-р сарын 3-18-ны хооронд аймаг, Улаанбаатар хотоос илгээсэн судалгааны явц**

| Аймаг/хот | Мэдээлэл оруулсан огноо | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4 сарын 03 | 4 сарын 10-13 | 4 сарын 14-17 | 4 сарын 17-18 | 4 сарын 18-30 |
| Улаанбаатар | 655 | 696 | 727 | 731 | 752 |
| Төв | 254 | 283 | 289 | 290 | 290 |
| Ховд | 115 | 115 | 115 | 115 | 115 |
| Говь-Алтай | 90 | 203 | 241 | 305 | 343 |
| Дорнод | 68 | 117 | 117 | 140 | 141 |
| Завхан | 29 | 29 | 29 | 29 | 29 |
| Дархан-Уул | 25 | 121 | 154 | 154 | 158 |
| Дундговь | 17 | 31 | 31 | 31 | 37 |
| Баянхонгор | 16 | 24 | 32 | 38 | 43 |
| Сүхбаатар | 16 | 18 | 18 | 18 | 18 |
| Орхон | 13 | 54 | 54 | 54 | 54 |
| Хөвсгөл | 10 | 25 | 38 | 50 | 188 |
| Булган | 9 | 73 | 201 | 302 | 471 |
| Сэлэнгэ | 7 | 8 | 9 | 9 | 9 |
| Говьсүмбэр | 6 | 33 | 36 | 36 | 36 |
| Өвөрхангай | 5 | 32 | 40 | 41 | 43 |
| Увс | 4 | 4 | 15 | 28 | 35 |
| Өмнөговь | 3 | 3 | 3 | 3 | 3 |
| Дорноговь | 2 | 149 | 159 | 159 | 159 |
| Хэнтий | 1 | 5 | 5 | 5 | 6 |
| Архангай | 0 | 0 | 9 | 11 | 14 |
| Баян-Өлгий | 0 | 0 | 118 | 200 | 303 |

### 3.3 Бэрхшээл болон сургамж

Судалгааны баг нь уламжлалт буюу бэлтгэгдсэн судлаачид, кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилсан судлаачид гэсэн 2 бүлэг тус бүр ажиглах аргачлалыг турших судалгааг амжилттай хэрэгжүүлсэн.

Бидний туршлагаас харахад бэлтгэгдсэн судлаачдад суурилсан ажиглалтын судалгааны аргачлал нь өртөг өндөр ч, богино хугацаанд холбогдох мэдээллийг авах боломжийг олгож байсан. Мөн үнэн зөв мэдээлэл цуглуулах байдал нь судлах асуудлын тухай судлаачийн ойлголтоос хамаарч байлаа. Уламжлалт аргатай харьцуулахад кроувдсоурсинг буюу олон нийтэд суурилсан судалгаа нь идэвхижүүлэх сэдэл бүхий сурталчилгааны ажил, маркетингийн төлөвлөгөө, мониторинг боловсруулах зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд хугацаа урт, тодорхой төсөв шаардагдахаас гадна орон нутгийн зохицуулагчдын маркетингийн төлөвлөгөө, мониторинг боловсруулах ур чадвар, туршлагаас хамаарч байв.

Судалгааны явцад тулгарсан бэрхшээлийн талаар товч дүгнэхэд:

1. Гар утасны технологийг ашиглах-Монголд шинэлэг зүйл байсан бөгөөд энэ нь бидний хувьд сорилт болсон юм.
2. Судалгаа авах газрын найдвартай, шаардлагатай мэдээлэл дутмаг-аргачлалыг эцэслэх хугацаа хойшлогдож байна.
3. Орон нутагт судалгааг явуулах цаг (өвлийн улирал)-судлаачдын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, ажиглалтын төлөвлөсөн газруудад хүрч очих боломжгүй байх. Баян-Өлгий аймгийн Булган сумыг Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаар солих тохиолдол гарсан.
4. Судалгаа авах газарзүйн өөрчлөлт-нийслэлийн 4 дүүрэг, 8 аймгийг хамруулахаар төлөвлөсөн ч бүх 21 аймгийг хамарч өргөжсөн. Энэ нь хүний нөөц, төсөвт асуудал үүсгэсэн.
5. Кроувдсоурсинг судалгааны хувьд цаг хугацаа богино буюу 3 сарын туршид хийх байсан боловч ердөө 2 сарын туршид хийсэн, төсөв хязгаарлагдмал байсан.
6. Энэхүү программ нь Samsung-ийн 5, iPhone 3-аас доош хувилбартай утсанд тохирохгүй байсан. Энэ нь мэдээлэл ирүүлэх тоог хязгаарласан.
7. Техникийн зарим хязгаарлалт-байршлын баталгаажуулалт хийхийн тулд интернетэд нэвтрэх шаардлагатай, Монголд интернетийн хүртээмж хязгаарлагдмал, заавал дата худалдаж авах юмуу интернеттэй орчинд судалгааг бөглөж, илгээдэг тул мэдээлэл ирүүлэх тоо багасахад нөлөөлсөн.
8. Аппликейшний сайжруулалт хойшлогдсон нь мэдээлэл цуглуулахад нөлөөлсөн.
9. Сугалаа зохион байгуулсан нь хүмүүсийг судалгаанд хамрагдах сэдэл төрүүлэх сайн хөшүүрэг болсон. Гэхдээ урамшууллын үйл ажиллагаанд дасан зохицохыг хүлээж байхад бидний кампанит ажил дууслаа. Одоо бид үр дүнг нь хүлээж байна.

### 3.4 Урьдчилсан дүн шинжилгээ, зөвлөмж, нэмэлт тайлан

Мэдээллийн нэгдсэн шинжилгээг ДЭМБ-д хийнэ. 2019 оны 6-7-р саруудад туршилтын 7 орны туршлагыг харьцуулж үндэслэсэн олон улсын тайлан бэлэн болно гэж үзэж байна. Тайланг хүлээн авсны дараа судалгааны баг 2019 оны 9-р сар хүртэл семинар зохион байгуулна.

**Хүснэгт 6. Туршилтын судалгаанд оролцсон орнуудын товч танилцуулга**

| Улс | Хүн ам | Насанд хүрэгчдийн өдрийн тамхидалтын тархалт | Тамхигүй орчин бүрдүүлэх заалтын хэрэгжилт | Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглосон заалтын хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Чили | 18 сая | 26% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон. Хэрэгжилт сайн. | ТВ, радио, хэвлэл мэдээлэлээр зарим төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт сайн |
| Монгол | 3 сая | 22% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт сайн | Бүх төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт сайн |
| Пакистан | 200 сая | 16% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт муу | ТВ, радио, хэвлэл мэдээлэлээр зарим төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт сайн |
| Румын | 20 сая | 25% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт сайн | ТВ, радио, хэвлэл мэдээлэлээр зарим төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт сайн |
| Сэйшелийн арал | 95.000 | 17% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт сайн | ТВ, радио, хэвлэл мэдээлэлээр зарим төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт сайн |
| Тайланд | 70 сая | 17% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт тодорхойгүй | ТВ, радио, хэвлэл мэдээлэлээр зарим төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт тодорхойгүй |
| Уганда | 42 сая | 7% | Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон, Хэрэгжилт тодорхойгүй | Бүх төрлийн зар сурталчилгааг хориглосон, хэрэгжилт тодорхойгүй |

*Эх үүсвэр: ДЭМБ-ын Дэлхийн тамхины хэрэглээний тархалтын тайлан. 2017*

## Нэмэлт тайлан: Монгол улс

Энэ бол тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа болон дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэхийг хориглох заалтын хэрэгжилтийн байдалд хяналт хийх тархаан өргөжүүлж болох аргачлалыг тодорхойлох туршилтын судалгааны төслийн эцсийн тайлангийн нэмэлт хэсэг юм.

Төслийн зорилго нь уламжлалт, кроувдсоурсинг, болон өргөтгөсөн шинжээчдийн судалгаа зэрэг гурван аргыг турших замаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) үнэн зөв бөгөөд харьцуулж болохуйц тоо мэдээллийг тайлагнах чадавхийг бэхжүүлэхэд оршиж байв. Уламжлалт болон кроувдсоурсинг судалгааны тоо мэдээллийг TobaccoSpotter гар утасны аппликейшнээр, харин шинжээчдийн үнэлгээг асуумж бөглүүлэх замаар тус тус цуглуулсан. Эдгээр судалгааны аргуудыг мэдээллийн чанар, гүйцэтгэсэн хугацаа болон өртгийн хувьд нь харьцуулсан. Туршилтын судалгаанд газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, орлогын түвшин, технологийн нэвтрэлтийн түвшнээрээ ялгаатай 7 орон оролцсон.

Судалгааны тоо мэдээллийг гар утасны аппликейшний хяналтын самбар дээр байршуулсны дараа нийцэл ба ялгаатай байдлын ажиглалтыг нь шалгаж байв. Ялангуяа, тамхигүй орчныг уламжлалт аргаар үнэлсэн судалгааны тоо мэдээллийг сайтар шалгаж байсан нь ажиглалт бүрийг сонгогдсон анхдагч түүврийн нэгжүүдийн аль нэгнээс авч байсантай холбоотой байсан.

Хэд хэдэн ажиглалтын нэгжийн байршлын мэдээлэл зөрүүтэй байсан тул ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын хэрэгжүүлэгч агентлаг нь судлаачдын бүртгэл, судалгааны газруудын талаархи мэдлэг, ба шаардлагатай бусад арга ашиглан гараар мэдээллийг шалган, цэгцэлсэн. Гараар цэвэрлэх ажил хангалтгүй байсан тохиолдолд “shape file”-ын аргыг ашиглан, системд бүртгэгдсэн уртраг ба өргөрөгийн координатаар тухайн хот эсвэл дүүргийн байршил, хилийг харуулсан газрын зурагтай ижил файл үүсгэх замаар тохируулж байсан.

Уламжлалт судалгааны үр дүн сонгосон анхдагч түүврийн нэгжүүдэд илрээгүй тохиолдолд үл нийцэх түвшинг жинлээгүй байдлаар тооцож үзсэн боловч жинлэсэн утга нь тэгтэй тэнцүү байсан. Хуулийн заалтын хэрэгжилтийн түвшний ангиллыг шинжээчидтэй уулзаж дараах байдлаар тогтоосон: 0-3.99 хувь Хэрэгждэггүй-Хэрэгжилтийн түвшин өндөр; 4.00-14.99 хувь Хэрэгждэггүй-Хэрэгжилтийн түвшин дунд зэрэг; дор хаяж 15 хувь Хэрэгждэггүй-Хэрэгжилтийн түвшин бага. Өргөтгөсөн шинжээчдийн судалгааны хувьд хариултыг тоон үзүүлэлт болгон хөрвүүлсэн буюу Хэрэгжилт өндөр бол 2 оноо, дунд зэрэг бол 1 оноо, муу бол оноо өгөөгүй. Бүх онооны дундажийг тооцоолж, дараа нь бүх онооны дундажийг хоёрт хуваагаад, гарсан дүнг 10-аар үржүүлэх замаар 10 зэрэгт ангилсан. Үүнд: 0-2.99-Бага дагаж мөрддөг, 3.00-7.99-Дунд зэрэг дагаж мөрддөг, болон 8.00-10-Сайн дагаж мөрддөг.

Энэхүү тайланд Монгол оронтой холбоотой бүх үр дүн болон тоо мэдээллийн тайлбар орсон. Тайлангаар холбогдох мэдээллийг тухайн оронд танилцуулахад анхаарсан бөгөөд цаашид дүн шинжилгээ хийх эсэхийг ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газар шийднэ.

*Жич: Эх мэдээний санг Excel файлаар, Stata программын дүн шинжилгээний үр дүн, болон эх мэдээний сангаас үр дүн боловсруулахад ашигласан Do-file зэргийг хавсралтаар оруулсан.*

## Үр дүнгийн хураангуй:

Хүснэгт 1 нь судалгааны гурван аргаар цуглуулсан нийт мэдээлийн тоог нэгтгэн харуулав. Ижилхэн тамхигүй орчин, тамхи худалдаалах цэгээс/газраас ирсэн олон хариултыг давхардлыг шалгасан тул дээрх тоо буурч ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Сурталчилгааны самбар, нийтийн тээврийн хэрэгсэлд давхардсан байдлыг үнэлэх боломжгүй байснаас эдгээр хоёр ангиллын бүх ажиглалтын тоог авч үзсэн болно.

Кроувдсоурсингийн судалгаанд оролцогчдын ажиглалт хийсэн өвөрмөц газруудын тоо нь уламжлалт судалгаанаас бага байсан. Кроувдсоурсингийн судалгаанд оролцогчдын ихэнх нь зөвхөн нэг л судалгаа илгээж байсан бол зарим нь 100 гаруйг ирүүлсэн байна. Бүх шинжээчид нь өргөтгөсөн шинжээчдийн асуумжийг хариулсан.

**Хүснэгт 1. Мэдээллийн сангийн үзүүлэлт, Монгол**

| | | |
|---|---|---|
| **Уламжлалт** | | |
| Судалгаанд хамрагдсан нэгжийн тоо | | 3251 |
| **Кроувдсоурсинг** | | |
| Илгээсэн тоо | | 2805 |
| Хүйс | Эрэгтэй | 439 (37.7%) |
| | Эмэгтэй | 725 (61.3%) |
| Насны бүлгээр | 18-29 | 469 (40.3%) |
| | 30-44 | 472 (40.6%) |
| | 45 ба дээш | 211 (18.1%) |
| Хэрэглэгч бүрийн илгээсэн мэдээллийн тоо | Доод | 1 |
| | Медиан | 1 |
| | Дээд | 126 |
| Нэг нэгжээс олонтоо илгээсэн байдал | Тамхигүй орчин (n) | 413 (24.71%) |
| | Худалдаалах цэг (n) | 64 (35.17%) |
| **Өргөтгөсөн шинжээчид** | | |
| Шинжээчдийн тоо | | 60 (100%) |

**Зураг 1. Уламжлалт ба Кроувдсоурсингийн судалгааг явуулсан газарзүйн байршил, Монгол улс**



Дээрх газрын зураг нь уламжлалт болон кроувдсоурсинг судалгаанд хамрагдсан байршлын тархалтыг харуулав. Сонгогдоогүй зарим байршлаас кроувдсоурсинг судалгаанд оролцсон байгааг харж болно.

**Хүснэгт 2. Хуулийн заалт хэрэгжээгүй газруудын эзлэх хувь (Уламжлалт судалгаанаас, жинлээгүй), Монгол улс**

| **Үзүүлэлт** | **Тоо** | **Хэрэгжээгүй байдал** | |
|---|---|---|---|
| | | % | 95 % CI |
| **Бүх нэгж*** | 2301 | 5.78% | 4.90%-6.81% |
| **Нийтийн тээврээс бусад нэгж** | | | |
| Эмнэлэг/эрүүл мэндийн төв | 215 | 0.47% | 0.06%-3.27% |
| Бага/дунд сургууль | 160 | 0.63% | 0.09 %-4.28% |
| Их сургууль/коллеж | 47 | 0% | |
| Төрийн байгууллага | 568 | 6.16% | 4.45 %-8.47% |
| Хувийн байгууллага | 454 | 5.51% | 3.74 %-8.03% |
| Ресторан | 376 | 5.05% | 3.24 %-7.8% |
| Кафе, паб, баар | 292 | 3.42% | 1.85 %-6.27% |
| **Нийтийн тээвэр** | 189 | 22.22% | 16.81 %-28.77% |
| **Бусад** | 126 | 6.35% | 3.18 %-12.29% |

* Бусад улстай ижил байх үүднээс "Бусад" гэж ангилагдсан газруудыг оруулаагүй болно. Ихэнх газрууд нь хуулийг дагаж мөрдөх байдал дунд зэрэг, харин нийтийн тээврийн хэрэгсэлд бага байсан.

**Хүснэгт 3. Тамхи худалдаалах цэгүүд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаанаас заалт хэрэгжээгүй газруудын эзлэх хувь, Монгол улс**

| **Үзүүлэлт** | **Тоо** | **Хэрэгжээгүй байдал** | |
|---|---|---|---|
| | | % | 95%CI |
| **Худалдаалах цэг** | 520 | 23.27% | 19.83%-27.11% |
| **Мэдээллийн хэрэгслийн бүх төрөл** | | | |
| Самбар | 201 | 2.06% | 0.76%-5.41% |
| Телевиз | 43 | 6.98% | 2.16%-20.30% |
| Радио | 27 | 3.70% | 0.45%-24.54% |
| Сонин | 10 | 0 | |
| Сэтгүүл | 20 | 0 | |

Хяналтын самбар дээрх өгөгдөл нь зөвхөн дээрх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийсэн ажиглалтыг багтаасан. Тамхи худалдаалах цэгийн судалгаанд хэрэгжихгүй байгаа түвшин өндөр, гэвч ерөнхийдөө хэвлэл мэдээллийн судалгаанд үл хэрэгжих байдал бага байна.

Хүснэгт 4 нь судалгааны гурван хэлбэрийн уламжлалт болон кроувдсоурсинг судалгааны мэдээллээс хэрэгжихгүй байгаа түвшинг харьцуулж харуулав. Уламжлалт болон кроувдсоурсинг судалгааны үр дүнгээс харахад тамхигүй газрууд, борлуулалтын цэгүүд, мэдээллийн хэрэгсэл хоорондын хувиудад статистик ач холбогдол бүхий ялгаа харагдаж байв. Энэ нь дээрх судалгааны хоёр аргаар хэрэгжихгүй байгаа байдлын тооцоолол ялгаатай байгааг харуулж байна.

**Хүснэгт 4. Уламжлалт ба кроувдсоурсинг судалгааны үр дүнгийн харьцуулалт, Монгол улс**

| Шалгуур үзүүлэлт | Уламжлалт | | Кроувдсоурсинг | | P-утга |
|---|---|---|---|---|---|
| | Судалгааны нэгжийн тоо (n) | Хэрэгжилтийн түвшин[a] (%) | Илгээсэн судалгааны тоо | Хэрэгжилтийн түвшин[b] (%) | |
| Тамхигүй орчин | 2427 | 5.81% | 1899 | 19.96% | <0.001 |
| Худалдаалах цэг | 520 | 23.27% | 240 | 51.67% | <0.001 |
| Медиа | 294 | 2.72% | 650 | 17.54% | <0.001 |

[a] жинлэгдээгүй, нэг нэгжээс олон илгээсэн байдлаар тохируулсан

[b] нэг нэгжээс олон илгээсэн байдлаар тохируулсан

**Зураг 2. Өргөтгөсөн шинжээчид ба GTCR[3]-ийн түвшинг харьцуулсан байдал, Монгол улс**




Дээрх зургаас харахад, Дэлхийн тамхины хяналтын тайлан ба өргөтгөсөн шинжээчдийн судалгааны үр дүн хоорондоо бүрэн нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Гэсэн ч өөр бусад судалгаануудаас харахад Монгол улсад тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийн байдал ерөнхийдөө дунд зэрэгтэй байна.

Хүснэгт 5-д дөрвөн судалгааны дүн, тэдгээрийн харгалзах ангиллыг нэгтгэв. Ерөнхийдөө бусад судалгаагаар хэрэгжилтийн түвшин дунд зэрэг гэсэн байхад кроувдсоурсинг судалгаагаар хэрэгжилт бага гэж гарчээ. Шинжээчдийн өргөтгөсөн болон ДТХТ яг ижил үр дүн гарсан бол уламжлалт судалгааны үр дүн өөр өөр судалгаанд ялгаатай үр дүнг үзүүлжээ.

[3] GTCR – Global Tobacco Control Report - Дэлхийн Тамхины Хяналтын Тайлан

**Хүснэгт 5. Уламжлалт, кроувдсоурсинг, шинжээчдийн судалгаа ба ДТХТ-ийн Монгол улс дахь судалгааны үр дүнгийн харьцуулалт**

| Шалгуур үзүүлэлт | Уламжлалт | | Кроувдсоурсинг | | Шинжээчид | | ДТХТ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хэрэгжихгүй байгаа [a] | Түвшин[b] | Хэрэгжихгүй байгаа [a] | Түвшин[b] | Оноо | Түвшин[c] | Оноо | Түвшин[c] |
| Тамхигүй орчин | 5.81% | Дунд | 5.81% | Бага | 3.83 | Дунд | 5 | Дунд |
| Худалдаалах цэг | 23.27% | Бага | 23.27% | Бага | 5.75 | Дунд | 7.5 | Дунд |
| Мэдээллийн хэрэгсэл | 2.72% | Өндөр | 2.72% | Бага | 5.08 | Дунд | 5 | Дунд |

[a] Жинлэгдээгүй тооцоолол

[b] Шижээчдийн тогтоосон түвшнээр: Хэрэгжилтийн түвшин өндөр-0-4 хувь хэрэгждэггүй; Хэрэгжилтийн түвшин дунд-5-15 хувь хэрэгждэггүй; Хэрэгжилтийн түвшин бага->15 хувь хэрэгждэггүй.

[c] Дэлхийн тамхины тархалтын талаарх ДЭМБ-ын тайланд тогтоосон ангилал: Хэрэгжилт өндөр-дундаж оноо 8.00-10.00, Хэрэгжилт дунд зэрэг-дундаж оноо 3.00-7.99, Хэрэгжилт бага-дундаж оноо 0.00-2.99

**Хүснэгт 6. Судалгааны төрөл бүрт зарцуулсан зардал, хугацаа**

| Үзүүлэлт | Уламжлалт | Кроувдсоурсинг | Шинжээчид |
|---|---|---|---|
| **Зардал (төгрөг)** | | | |
| Ажилтнууд (цалин) | 61 131 254 | -- | 15 840 000 |
| Материал, хангамж, технологи | 3 075 040 | 8 000 000 | -- |
| Сургалт, тээврийн зардал, хүнс | 25 011 100 | 2 000 000 | -- |
| Бусад нэмэлт зардал (орчуулга) | 5 835 000 | -- | -- |
| **Хугацаа (өдөр)** | | | |
| Судалгааны бэлтгэл | 57 | 193 | 39 |
| Судалгааны хэрэгжилт | 92 | 76 | 46 |
| Судалгааны дараах | -- | -- | -- |

Хүснэгт 6-д зардлын хуваарилалт, судалгааны хэсэг тус бүрийг авсан хугацаа зэргийг нэгтгэн харуулав. Төсвийн ихэнх хувийг судлаачдын цалин, урамшууллын зардалд зарцуулсан. Кроувдсоурсинг судалгааны бэлтгэл ажилд хамгийн урт хугацаа зарцуулжээ.

**Хүснэгт 7. Урамшууллын үр нөлөө, Монгол улс**

| | Урамшууллын өмнө | Урамшууллын дараа |
|---|---|---|
| 7 хоногт бүртгүүлж байсан хэрэглэгчийн дундаж тоо | 47.94 | 63.15 |
| 7 хоногт хэрэглэгчийн илгээсэн судалгааны дундаж тоо | 0.145 | 0.559 |

Урамшууллын дараа оролцогчдын тоо болон аппликейшны идэвхтэй хэрэглэгчдийн тоо ихээхэн нэмэгдсэн.

# ХАВСРАЛТУУД

**ХАВСРАЛТ 1:** Үйл ажиллагааны төлөвлөгөө

**“Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх” туршилт судалгааны үйл ажиллагааны төлөвлөгөө**

| № | Хийгдэх ажлууд | | Хугацаа | Хариуцах эзэн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Судалгааны удирдамж орчуулах | | 8 сард | Е.Гүлжанат | Удирдамж орчуулагдана |
| 2. | Судалгааны асуумж орчуулах | | 8 сард | Е.Гүлжанат | Асуумж орчуулагдана |
| 3. | АШУҮИС-ийн НЭМС-аар судалгааны арга аргачлалыг батлуулах | | 9 сард | Ж.Гантулга С.Мөнхтуяа Е.Гүлжанат | Арга аргачлал батлагдаж, тэмдэглэл хөтлөгдөнө |
| 4. | ЭМЯ-ны ёс зүйн хорооны хурлаар судалгааны ёс зүйн зөвшөөрөл авах | | 9 сард | Ж.Гантулга С.Мөнхтуяа Е.Гүлжанат | Ёс зүйн зөвшөөрөл батлагдан, тэмдэглэл хөтлөгдөнө |
| 5. | Судлаач бэлтгэх сургалт | Түүврийн загвар | 9 сард | Е.Гүлжанат, Г.Мөнхзаяа | Хэрхэн түүвэрлэх тухай мэдээлэл бэлтгэнэ |
| | | Мэдээллийн хуудас /гэрээ/ | 9 сард | Е.Гүлжанат Б.Нацагсүрэн | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний загвар |
| | | Сургалт зохион байгуулах төлөвлөгөө | 9 сард | Е.Гүлжанат, Ж.Гантулга | Анхаарах зүйлсийн хуудас бэлтгэнэ |
| | | Харилцаа холбооны хэрэгсэл | 9 сард | Т.Мандхай, У.Бямбадорж | ТВ, радиогоор сурталчлах тараах материал бэлтгэнэ |
| | | Олон нийтэд зориулсан баримтын цомог | 9 сард | Т.Мандхай, У.Бямбадорж, П.Энхтуяа | Баримтын цомог боловсруулна, хэвлэнэ |
| | | Асуумжийн эцсийн хувилбар | 9 сард | К.Елена, С.Мөнхтуяа, Е.Гүлжанат, Ж.Гантулга | Англи, монгол хэлээр бэлтгэнэ |
| | | Тамхины судалгааны аппликейшн бөглөх зааварчилгаа | 9 сард | Ж.Гантулга, Г.Мөнхзаяа У.Бямбадорж, П.Энхтуяа | Аппликейшн бөглөх зааварчилгаа бүхий тараах материал бэлтгэнэ |
| | | Орон нутгийн сургалтын үйл ажиллагааны хуваарь | 9 сард | Е.Гүлжанат, Г.Мөнхзаяа П.Энхтуяа | Судалгаа хийх газарт түүврийн анхдагч нэгжийг хэрхэн сонгох хуудас бэлтгэнэ |
| | | ЕБС, их, дээд сургууль руу нэвтрэх зөвшөөрөл | 9 сард | Е.Гүлжанат, Б.Батцэцэг, Б.Нацагсүрэн | Албан бичгийг боловсруулна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүссэн албан бичиг | | | |
| | | Орон нутгийн удирдлагаас зөвшөөрөл авах | 9 сард | Е.Гүлжанат, Б.Батцэцэг, Б.Нацагсүрэн | Албан бичгийг боловсруулна |
| | | Судалгааны ажлын протоколын загвар | 9 сард | Е.Гүлжанат, Б.Батцэцэг, Б.Нацагсүрэн | Судлаач, хянагч хоёрын нэр, судалгаа хийсэн байршил, хугацааг нарийн тусгасан загвар хуудас боловсруулна |
| 6. | Харилцаа холбооны маркетинг стратеги | Маркетингийн төлөвлөгөө | 9-11 сар | Дулмаа Т.Мандхай, У.Бямбадорж, | Маркетингийн төлөвлөгөө боловсруулагдана |
| 7. | Судлаач бэлтгэх сургалт, судлаачдыг гарын авлагаар хангах | | 9 сар | Е.Гүлжанат, Б.Батцэцэг, Б.Нацагсүрэн | Судлаачдад зориулсан гарын авлага гаргасан байна |
| 8. | Улаанбаатар хотын судлаач бэлтгэх сургалт | | 9.24-26 | Судалгааны баг | 8 дүүргийн 40 судлаач оролцоно. |
| 9. | Хөдөө орон нутгийн судлаач бэлтгэх сургалт | | 9.28-30 | Судалгааны баг | 8 аймгийн 40 судлаач Архангай аймагт сургалтанд оролцоно. |
| 10. | Судалгааны мэдээлэл цуглуулах | | 10.1-10.30 | Судалгааны баг | 8 аймаг, 8 дүүргийн хэмжээнд мэдээлэл цуглуулна. |
| 11. | Хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх | | 10.01-10.30 | Судалгааны баг | Аймаг тус бүрт 2 судлаач хөндлөнгийн хяналт хийнэ |
| 12. | Мэдээллийн сан хүлээлгэж өгөх, хяналт хийх | | 11.01-11.10 | Судалгааны баг | Бүрэн бөглөсөн эсэх нягтлан хүлээн авах |
| 13. | Мэдээллийн сан шивэх | | 11.10-11.20 | Э.Тамир В.Байгалмаа Л.Даваасүрэн | SPSS 21 программд мэдээлэл оруулах |
| 14. | Статистик боловсруулалт хийх | | 11.20-11.30 | Т.Ганцэцэг У.Бямбадорж Алтансүх | Цаасан боловсруулалт Апп суурилсан боловсруулалт |
| 15. | Судалгааны тайлан бичих | | 11.30-12.15 | ДЭМБ В.Баярмаа | Тайлангийн ном |
| 16. | Судалгааны тайланг орчуулах, хэвлүүлэх | | 12.15-12.30 | ДЭМБ К.Елена | Тайлангийн ном |
| 17. | Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх | | 12.01-12.30 | ДЭМБ В.Баярмаа | 2 өгүүлэл |
| 18. | Тайлангийн хурал | | 2019.01 сард | Судалгааны баг | Үр дүнгээр олон нийтэд тайлангийн хурал зохион байгуулах |

Төлөвлөгөө боловсруулсан: Төслийн зохицуулагч В.Баярмаа, дэд захирал

**ХАВСРАЛТ 2:** Мэдээлэл солилцох гэрээ (Англи хувилбарын 35-р хуудас)

**ХАВСРАЛТ 3:** Судалгааны асуумж

| **Судалгаа бөглөх** |
|---|
| Та Улаанбаатар хотын судалгаанд оролцож байна.<br>Судалгааны төрлөө сонгоно уу!<br>o Нийтийн эзэмшлийн газар-Тамхигүй орчин судалгаа<br>o Тамхины зар сурталчилгаа-Худалдаалж буй цэгийн судалгаа<br>o Тамхины зар сурталчилгаа-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа |
| **Тамхигүй орчин** (Утаат тамхи татахыг хориглох)<br>***Шаардлагатай нэгжийн нэрсийг харуулсан**<br>Та ямар нэгжид ажиглалт хийх гэж байна вэ? *<br>o Эмнэлэг/эрүүл мэндийн төв<br>o Бага/дунд сургууль<br>o Их сургууль, коллеж<br>o Төрийн байгууллагын байр<br>o Хувийн хэвшлийн байгууллага<br>o Ресторан<br>o Кафе/Паб/Баар<br>o Нийтийн тээвэр<br>o Бусад<br>1. Тухайн нэгжид судалгаа хийх боломжтой эсэх?*<br>o Тийм<br>o Үгүй<br>*Боломжгүй байсан шалтгаан*<br>*(i) Байхгүй/ хаагдсан*<br>*(ii) Олж чадаагүй*<br>*(iii) Удирдлагын зүгээс нь зөвшөөрөөгүй*<br>*(iv) Бусад (тодруулж бичих)*<br>2. Тус нэгжид хэн нэгэн усан тамхи татаж байхыг харсан эсэх?*<br>o Тийм, дотоод орчинд<br>o Тийм, хагас нээлттэй орчинд<br>o Үгүй<br>3. Тухайн байгууллагын дотоод орчинд тамхи татаж буй хүн харсан уу?*<br>o Тийм, дотоод орчинд<br>o Тийм, хагас нээлттэй орчинд<br>o Үгүй<br>4. Тухайн нэгжид үнсний сав харагдаж байна уу?*<br>o Тийм, дотоод орчинд<br>o Тийм, хагас нээлттэй орчинд<br>o Үгүй<br>5. Тухайн нэгжид тамхи татахыг хориглоно гэсэн тэмдэглэгээ байна уу?*<br>o Тийм, дотоод орчинд<br>o Тийм, хагас нээлттэй орчинд<br>o Үгүй<br>6. Тухайн нэгжид тамхины иш харагдаж байна уу?*<br>o Тийм, дотоод орчинд<br>o Тийм, хагас нээлттэй орчинд<br>o Үгүй |

7. Тухайн нэгжид тамхины хяналтын хуулийг зөрчтсөн тохиолдлыг мэдээллэх тухайн санамжийг ил харагдахьуйц газар байршуулсан байна уу?*

- o Тийм, дотоод орчинд
- o Тийм, хагас нээлттэй орчинд
- o Үгүй

*Нийтийн тээврийн хэрэгсэл:*
Автобус
Такси
Вагон
Автобусны буудал, такси хүлээлэг эсвэл вагоны буудал дээр
***Асуулт:*** Та тамхи татаж буй хүн харж байна уу?

Судалгааны төрлөө сонгоно уу!

- o Нийтийн эзэмшлийн газар-Тамхигүй орчин судалгаа
- o Тамхины зар сурталчилгаа-Худалдаалж буй цэгийн судалгаа
- o Тамхины зар сурталчилгаа-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа

**Тамхин бүтээгдэхүүний сурталчилгаа**
(*) **Шаардлагатай нэгжийн нэрсийг харуулсан**
* Албан байгууллагын төрлөө сонгоно уу?

- o ТҮЦ
- o Супермаркет
- o Хүнсний дэлгүүр
- o Шатахуун түгээх станц
- o Сонин борлуулах цэг
- o Орон сууцны эсвэл жижиг талбайтай хүнс зардаг газар
- o Бусад

1. Тухайн нэгжид судалгаа хийх боломжтой эсэх? *

- o Тийм
- o Үгүй

*Боломжгүй байсан шалтгаан*
*(i) Байхгүй/ хаагдсан*
*(ii) Олж чадаагүй*
*(iii) Удирдлагын зүгээс нь зөвшөөрөөгүй*
*(iv) Бусад (тодруулж бичих)*

2. Тухайн тамхи худалдаж буй цэгт тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгаа байна уу?*

- o Тийм, дотор талд нь
- o Тийм, гадна талдаа
- o Үгүй, харагдахгүй байна

3. Тамхин бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчид ил харагдахьуйц газарт байршуулсан байна уу?*

- o Тийм
- o Үгүй

4. Үнийн хямдралтай эсвэл бэлгийн шагналтай худалдаа, эсвэл өвөрмөц буюу тодорхой хугацаатай урамшуулал бүхий тамхин бүтээгдэхүүн зарж борлуулж байна уу?*

- o Тийм
- o Үгүй

5. Тамхины брендтэй ижил нэртэй тамхин бус бүтээгдэхүүн харсан тохиолдол байна уу?*

- o Тийм
- o Үгүй

6. Тамхин бус бүтээгдэхүүнд тамхин бүтээгдхүүний брэндийн нэрийг ашигласан тохиолдол байна уу?*

- Тийм
- Үгүй

Судалгааны төрлөө сонгоно уу!

- Нийтийн эзэмшлийн газар-Тамхигүй орчин судалгаа
- Тамхины зар сурталчилгаа-Худалдаалж буй цэгийн судалгаа
- Тамхины зар сурталчилгаа-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа

**Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тамхи сурталчилах**
**(*)Шаардлагатай нэгжийн нэрсийг харуулсан**
Хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлөө сонгоно уу*

- Зарлалын самбар
- Телевиз
  -Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз
  -Хувийн телевизүүд
- Радио
  -Монголын Үндэсний Олон Нийтийн Радио
  -Хувийн FM
- Сонин
- Сэтгүүл

2. Тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгааг харсан уу?*

- Тийм
- Үгүй

3. Тамхин бус бүтээгдэхүүнийг тамхины брендээр нэрлэснийг харсан уу?*

- Тийм
- Үгүй

4. Тамхин бус бүтээгдэхүүний брендээр тамхин бүтээгдэхүүнийг нэрлэснийг харсан уу?*

- Тийм
- Үгүй

5. Тамхитай холбоотой ивээн тэтгэлэгийн жишээ (урлаг, спортын арга хэмжээ, энтертайнмент) харсан байна уу?*

- Тийм
- Үгүй

**ХАВСРАЛТ 4:** Tobacco spotter ашиглах заавар

## I. Судалгааны төрөл сонгох

Tobacco Spotter аппликейшнээр 3 төрлийн судалгаа бөглөх боломжтой.

- Нийтийн эзэмшлийн газар-Тамхигүй орчин судалгаа
- Тамхины зар сурталчилгаа-Худалдааны цэгийн судалгаа
- Тамхины зар сурталчилгаа-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа



## II. Судалгаа хийх

### a. Нийтийн эзэмшлийн газар-Тамхигүй орчны судалгаа




1. Нийтийн эзэмшлийн газар/нийтийн тээврийн төрлийг дараах жагсаалтаас сонгоно уу.
   - **Газрын зураг** эсвэл **Жагсаалт**
   - **Байршлаар хайх**

   *Байгууллагыг гар аргаар нэмж болно (Бусад хэсгээс харна уу).*
2. Байгууллагын төрлийг сонгосны дараа судалгааг эхлүүлэхийн тулд **Судалгаа бөглөх** товчлуурыг дарна.
3. Сайтар ажиглалт хийсний дараа судалгааны асуултыг бөглөнө. (Үгэн болон зурган зааварчилгаатай **нүд тэмдгийг** дарж танилцана уу.)
4. Судалгааг илгээхдээ **цэнхэр өнгөтэй зөв тэмдгийг** дарна.

### b. Тамхины зар сурталчилгаа-Худалдааны цэгийн судалгаа




1. Худалдааны цэгийн төрлийг дараах жагсаалтаас сонгоно уу.
   - **Газрын зураг** эсвэл **Жагсаалт**
   - **Байршлаар хайх**

   *Байгууллагыг гар аргаар нэмж болно (Бусад хэсгээс харна уу)*
2. Байгууллагын төрлийг сонгосны дараа судалгааг эхлүүлэхдээ **Судалгаа бөглөх** товчлуурыг дарна.
3. Сайтар ажиглалт хийсний дараа судалгааны асуултыг бөглөнө. (Үгэн болон зурган зааварчилгаатай **нүд тэмдгийг** дарж танилцана уу.) Судалгаатай хамт зураг аваад илгээх боломжтой.
4. Судалгааг илгээхдээ **цэнхэр өнгөтэй зөв тэмдгийг** дарна.

c. Тамхины зар сурталчилгаа-Хэвлэл мэдээллийн хэрэгслийн судалгаа




1. Ажиглалт хийх хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрлийг сонгоно.
2. Ажиглаж байгаа **хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэлбэрийг** сонгоно. (зарлалын самбараас бусад)
3. Сайтар ажиглалт хийсний дараа судалгааны асуултыг бөглөнө. (Үгэн болон зурган зааварчилгаатай **нүд тэмдгийг** дарж танилцана уу.) Судалгаатай хамт зураг аваад илгээх боломжтой.
4. Судалгааг илгээхдээ **цэнхэр өнгөтэй зөв тэмдгийг** дарна.

## III. Бусад

a. Шинээр байгууллага нэмэх (газрын зураг ба жагсаалтанд байхгүй тохиолдолд)




1. Газрын зураг дээрх **нэмэх (+) тэмдгийг** дарна.
2. ***Байгууллагын нэрийг оруулна.***
3. Шинээр нэмж буй **байгууллагын төрлийг** сонгоод **цэнхэр өнгөтэй зөв тэмдгийг** дарна.

*Байгууллагыг нэмсэний дараа* ***байгууллагын нэр*** *газрын зургийн дээд хэсэгт гарч ирнэ. Шинээр нэмэгдсэн байгууллагад судалгаа хийхэд* ***судалгаа бөглөх*** *товчлуурыг дарж судалгааг хийнэ.*

b. Оффлайн горимд хийх судалгаа




*Та интернетгүй орчинд* ***оффлайн горимд*** *судалгаа хийх боломжтой. Ажиглалт хийж бүх асуултыг бөглөсний дараа* **цэнхэр өнгөтэй зөв тэмдгийг** дарж судалгаа илгээнэ.

1. Оффлайн горимд бөглөсөн судалгаа үндсэн хуудсын цэсний баруун дээд буланд байрлах **үүлний зурган** дээр тоогоор харагдана. Оффлайн горимд хийсэн судалгааны жагсаалтыг харахын тулд **үүлний зурган** дээр дарна.
2. Интернет орчинтой холбогдоод үүлний зурган дээр дарж товч мэдээлэл рүү орон баруун доод булан байрлах **цэнхэр өнгөтэй давхар зөв тэмдгийг** дарж оффлайн горимд бөглөсөн судалгааг илгээнэ. Судалгааг амжилттай илгээсэн мэдээлэл гарч ирнэ.

## IV. Нэмэлт цэс




Нэмэлт цэсээс доорхи үйл ажиллагааны зааварчилгаа харах боломжтой.

1. ***Бөглөж дууссан судалгаа***: Бөглөж дуусаад серверт илгээсэн бүх судалгааны жагсаалт харагдана.
2. ***Надтай ойролцоо байгаа газар/нэгж***: Таны одоо байгаа газартай ойролцоо байрласан нэгж байгууллагуудын жагсаалт харагдана.
3. ***Тохиргоо***
   a. **Хэл солих горим**. Хоёр дахь сонголт нь Англи хэл
   **b. Аппликейшний агуулгыг дахин цэнэглэх**
   c. **Хэвэнд нь оруулах** бүх мэдээллийг устгаж дахин бүртгүүлнэ.
4. ***Зааварчилгаа***
   d. Аппликейшнийг ашиглах тухай **богино хэмжээний видео**
   **e.** Аппликейшнийг ашиглах тухай **хэрэглэгчийн гарын авлага**
5. ***Тусламж***
   **f.** Аппликейшний тухай **түгээмэл асуулт, хариултууд**
   g. Төрөл бүрийн нэгж байгууллага ба судалгааны **боломжит хувилбарууд**
6. ***Алтан дүрэм:*** Судалгаа хийх явцад **хийх ба хийж болохгүй** зүйлсийн жагсаалт

| |
|---|
| Tobacco Spotter гар утасны аппликейшнд тавтай морилно уу |
| Tobacco Spotter аппликейшнийг Тамхины хяналтын хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх ба тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох заалтуудын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор мэдээлэл цуглуулахад ашиглана. |
| ТАМХИ ТАТАХЫГ ХОРИГЛОНО |
| ТАМХИ СУРТАЛЧИЛАХЫГ ХОРИГЛОНО |
| Санаачилан гаргасан |
| Татаж авч суулгана уу<br>Google Play Store эсвэл Apple App store-аас татаж авна уу |
| Эхэлцгээе<br>Тохирох улс/хэлээ сонгоно уу |
| Бүртгүүлнэ үү<br>Мэдээллээ оруулна уу |
| Судалгаа |
| Бөглөх судалгааг сонгоно уу<br>3 төрлийн судалгаанаас сонгоно уу |
| Байгууллагаа сонгоно уу<br>Газрын зураг эсвэл жагсаалтаас байгууллагаа сонгоно уу |
| Судалгаа бөглөнө үү<br>Судалгааны асуултанд хариулна уу |
| Зураг хавсаргах<br>Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох заалтын судалгаанд зураг хавсаргаж болно. |
| OFFLINE (Интернетгүй орчин) |
| OFFLINE (Интернетгүй орчинд хийсэн судалгаа)<br>Интернетгүй орчинд хийсэн судалгааг хадгалж дамжуулах боломжтой |
| Дамжуулна уу<br>Интернеттэй холбогдоод хадгалагдсан судалгааг дамжуулна уу |
| БАЯРЛАЛАА! |

**ХАВСРАЛТ 6:** Судлаач бэлтгэх сургалт (Улаанбаатар, Архангай аймаг)

БАТЛАВ. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л.НАСАНЦЭНГЭЛ

**“Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, ивээн тэтгэлэгийг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” туршилт судалгааны судлаач бэлтгэх сургалтын хуваарь**

*9 дүгээр сарын 24-26 Улаанбаатар*

| **Хугацаа** | **Сэдэв** | **Илтгэгч** |
|---|---|---|
| **9 дүгэр сарын 24, Даваа гариг (Судалгааг зохион байгуулагч багтай хийх уулзалт)** | | |
| 10:00-10:40 | Нээлтийн үйл ажиллага | ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч<br>ЭМЯ-ны төлөөлөл |
| 10:40-11:00 | Танилцуулга: СЭМҮТ ба ДЭМБ-аас бүрдсэн судалгааны баг | СЭМҮТ-ийн ерөнхий захирал |
| 11:00-11:15 | Дурсгалын зураг | |
| 11:15-11:45 | Туршилт судалгааны тухай танилцуулга | Dr Kerstin Schotte |
| 11:45-12:00 | Тамхины хяналтын талаарх бүсийн хэтийн төлөв | Ms Mina Kashiwabara |
| 12:00-12:15 | Тамхины хяналтын талаарх Монгол улсын хэтийн төлөв | Ж.Наранчимэг<br>Монгол дахь ДЭМБ-ын мэргэжилтэн |
| 12:15-12:30 | Сургалтын тойм ба судалгааны тухай | Ms Mina Kashiwabara |
| 12:30-13:30 | *Үдийн хоол* | |
| 13:30-13:50 | Crowdsourcing-ийн тухай ойлголт (Crowdsourcing гэж юу вэ? Хэрхэн бий болсон бэ?)<br>Асуулт, хариулт<br>*Нэгэн зэрэг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: УБ хотод янз бүрийн байршлаас crowdsourcerүүд гар утасны аппликейшнийг татаж авч 2 цагийн турш хэрэглэх* | Mr Titus Karanja |
| 13:50-14:20 | Харилцаа холбооны стратеги бодлого | Ms Lizzie Tecson |
| 14:20-15:00 | Харилцаа холбооны стратеги бодлого хөгжүүлэх тухай хэлэлцүүлэг | Зохион байгуулагч байгууллага |
| 15:00-15:30 | Мэдээлэл боловсруулалт ба хянах самбар | Ms Marie Clem Carlos |
| 15:30-15:45 | *Цайны завсарлага* | |
| | Сургагдаагүй crowdsourcerүүд гар утасны аппликейшныг ашиглахад тулгарч буй бэрхшээл ба сурсан зүйлсийн талаарх хэлэлцүүлэг | |
| 16:05-17:00 | Судалгааны талбайн хэрэгжилтийн төлөвлөгөө | Зохион байгуулагч байгууллага |
| **9 дүгээр сарын 25, Мягмар гариг** | | |
| 9:30-10:00 | Нээлтийн үйл ажиллага | ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч<br>ЭМЯ-ны төлөөлөл |

| | | |
|---|---|---|
| 10:00-10:15 | Танилцуулга: СЭМҮТ ба ДЭМБ-аас бүрдсэн судалгааны баг, судлаачид | СЭМҮТ-ийн ерөнхий захирал |
| 10:15-10:30 | Дурсгалын зураг | |
| 10:30-10:45 | Туршилт судалгааны тухай танилцуулга | Dr Kerstin Schotte |
| 10:45-11:15 | Судалгааны протоколын тухай | Ms Marie Clem Carlos |
| 11:15-12:00 | Судалгааны протоколыг нутагшуулах<br>Мэдээлэл цуглуулах удирдамж | Зохион байгуулагч байгууллага |
| 12:00-12:30 | Асуулт,хариулт | |
| 12:30-13:30 | *Үдийн хоол* | |
| 13:30-13:40<br><br>13:40-14:00 | Гар утасны аппликейшний тухай ойлголт<br>*Tobacco Spotter* аппликейшнийг татаж авах | Mr Titus Karanja |
| 14:00-14:45 | Апп ашиглахад тулгарч буй сорилт ба бусад хувилбарууд. | |
| 14:45-15:00 | *Цайны завсарлага* | |
| 15:00-16:45 | Судалгааны талбайн хэрэгжилт<br>(гар утасны аппликейшн ба ойролцоо байрлах байгууллагад ажиглалт хийх)<br>*Зөвлөмж: 8-10 хүнтэй бүлэг болж судалгаанд хамрагдах байгууллагын 6 төрлөөс хамгийн багадаа нэг байгууллагатай очиж танилцах(ресторан, кафе, төрийн байгууллага, их дээд сургууль, нийтийн тээвэр, зар сурталчилгааны самбар)* | Зохион байгуулагч байгууллага |
| 16:45-17:00 | Оролцогчидоос санал авах, хэлэлцүүлэг | Ms Mina Kashiwabara |
| **9 дүгээр сарын 26, Лхагва гариг** | | |
| 09:30-12:30 | Судалгааны талбайн хэрэгжилт<br>(алслагдмал байрлах байгууллагуудад ажиглалт хийх)<br>*Зөвлөмж: 8-10 хүнтэй бүлэг болж судалгаанд хамрагдах байгууллагын 5 төрлөөс хамгийн багадаа нэг байгууллагатай очиж танилцах(эмнэлэг, эрүүл мэндийн төв, ЕБС, нийтийн тээвэр, жижиглэн худалдааны цэг)* | |
| 12:30-13:30 | *Үдийн хоол* | |
| 13:30-16:30 | Судалгааны нэгж дээр ажиллахад тулгарсан бэрхшээл ба суралцсан зүйлсийн талаар хэлэлцүүлэг | Ж.Наранчимэг<br>Монгол дахь ДЭМБ-ын мэргэжилтэн |
| 16:30-16:15 | *Цайны завсарлага* | |
| 16:15-17:00 | Хэлэлцүүлгийн үргэлжлэл<br>Хаалтын үйл ажиллагаа | ЭМЯ/ДЭМБ |

Боловсруулсан: Е.Гүлжанат, СЭМҮТ-ийн мэргэжилтэн
Ж.Гантулга, СЭМҮТ-ийн мэргэжилтэн

Хянасан: В.Баярмаа, СЭМҮТ-ийн НЭМЭШСГХ дэд захирал

БАТЛАВ. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л.НАСАНЦЭНГЭЛ

**“Тамхины хяналтын тухай хуулийн тамхигүй орчин бүрдүүлэх, тамхины зар сурталчилгаа, ивээн тэтгэлэгийг хориглох заалтын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” туршилт судалгааны судлаач бэлтгэх сургалтын хуваарь**

*9 дүгээр сарын 28-30 Архангай аймаг*

| Хугацаа | Сэдэв | Илтгэгч |
|---|---|---|
| **9 дүгээр сарын 28, Баасан гариг (Орон нутгийн судлаачдын сургалт)** | | |
| 09:30-10:00 | Нээлтийн үйл ажиллага | ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч<br>ЭМЯ-ны төлөөлөл |
| 10:00-10:15 | Танилцуулга: СЭМҮТ ба ДЭМБ-аас бүрдсэн судалгааны баг | СЭМҮТ-ийн ерөнхий захирал |
| 10:15-10:30 | Дурсгалын зураг | |
| 10:30-10:45 | Туршилт судалгааны тухай танилцуулга | Dr Kerstin Schotte |
| 10:45-11:15 | Тамхины хяналтын талаарх бүсийн хэтийн төлөв | Ms Mina Kashiwabara |
| 11:15-12:00 | Судалгааны протоколыг нутагшуулах<br>Мэдээлэл цуглуулах удирдамж | Зохион байгуулагч байгууллага |
| 12:00-12:30 | Асуулт, хариулт | |
| 12:30-13:30 | *Үдийн хоол* | |
| 13:30-13:40<br><br>13:40-14:00<br>14:00-14:45 | Гар утасны аппликейшний тухай ойлголт<br>*Tobacco Spotter* аппликейшнийг татаж авах<br>Апп ашиглахад тулгарч буй сорилт ба бусад хувилбарууд. | Mr Titus Karanja |
| 14:45-15:00 | *Цайны завсарлага* | |
| 15:00-16:45 | Архангай аймаг дахь судалгааны талбайн хэрэгжилт<br>(гар утасны аппликейшн ба ойролцоо байрлах байгууллагад ажиглалт хийх)<br>*Зөвлөмж: 8-10 хүнтэй бүлэг болж судалгаанд хамрагдах байгууллагын 6 төрлөөс хамгийн багадаа нэг байгууллагатай очиж танилцах(ресторан, кафе, төрийн байгууллага, их дээд сургууль, нийтийн тээвэр, зар сурталчилгааны самбар)* | Зохион байгуулагч байгууллага |
| 16:45-17:00 | Оролцогчдоос санал авах, хэлэлцүүлэг | Ж.Наранчимэг<br>Монгол дахь ДЭМБ-ын мэргэжилтэн |
| **9 дүгээр сарын 29, Бямба гариг** | | |

| | | |
|---|---|---|
| 9:30–12:30 | Судалгааны талбайн хэрэгжилт (алслагдмал байрлах байгууллагуудад ажиглалт хийх)<br>*Зөвлөмж: 8-10 хүнтэй бүлэг болж судалгаанд хамрагдах байгууллагын 5 төрлөөс хамгийн багадаа нэг байгууллагатай очиж танилцах(эмнэлэг, эрүүл мэндийн төв, ЕБС, нийтийн тээвэр, жижиглэн худалдааны цэг)* | |
| 12:30-13:30 | *Үдийн хоол* | 🍽 🍽 🍽 🍽 |
| 13:30-16:00 | Судалгааны нэгж дээр ажиллахад тулгарсан бэрхшээл ба суралцсан зүйлсийн талаар хэлэлцүүлэг | Ms Mina Kashiwabara |
| 16:00-16:15 | *Цайны завсарлага* | ☕☕☕ |
| 16:15-17:00 | Хэлэлцүүлгийн үргэлжлэл<br>Хаалтын үйл ажиллагаа | ЭМЯ / ДЭМБ |
| | **9 дүгээр сарын 30, Ням гариг** | |
| 09:30-09:50 | Crowdsourcing-ийн тухай ойлголт (Crowdsourcing гэж юу вэ? Хэрхэн бий болсон бэ?)<br>Асуулт, хариулт | Mr Titus Karanja |
| 09:50-10:20 | Харилцаа холбооны стратеги бодлого | Ms Lizzie Tecson |
| 10:20-11:30 | Харилцаа холбооны стратеги бодлого хөгжүүлэх тухай<br>Хэлэлцүүлэг | Зохион байгуулагч байгууллага |
| 11:30-12:30 | *Үдийн хоол* | 🍽 🍽 🍽 🍽 |
| 12:30–14:00 | Судалгааг хэрэгжүүлэгч багтай хамт дүгнэлт хийх<br>Судалгааны нэгж дээр ажиллахад тулгарсан бэрхшээл, суралцсан зүйлс ба сургагдаагүй crowdsourceруудад тулгарсан бэрхшээлийн талаарх хэлэлцүүлэг | |
| 14:00–15:00 | Мэдээлэлийн чанарын хяналт ба ашиглалт | |
| 15:00-15:30 | Хаалтын үйл ажиллагаа | ЭМЯ/ДЭМБ |

Боловсруулсан: Е.Гүлжанат, СЭМҮТ-ийн мэргэжилтэн
Ж.Гантулга, СЭМҮТ-ийн мэргэжилтэн

Хянасан: В.Баярмаа, СЭМҮТ-ийн НЭМЭШСГХ дэд захирал

**ХАВСРАЛТ 7:** Нийгмийн маркетингийн сурталчилгаа-Цагийн хуваарь


ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

13290 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Шархад, 9 дүгээр хороо, Утас/Факс: (976-11) 45 82 98,
E-mail: MGL_men.health@yahoo.com


2019.02.26 № 3/182

танай ____________-ны №_____________-т

АЙМГУУДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Тамхины туршилт судалгааг үргэлжлүүлэн явуулах тухай

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Монгол улсын "Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх" судалгааны эхний шат нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төв, сумдын аж ахуйн нэгж, албан байгууллага, сургуулийн доторх, гаднах тамхигүй орчин, тамхи худалдаалах цэг, нийтийн тээвэр, зарлалын самбарын тамхины зар сурталчилгааны хэрэгжилтийн байдлыг үнэлэх замаар хийгдээд дууссан билээ.

Дээрх судалгааны олон нийтэд тулгуурлан хийгдэх 2 дахь шатны судалгаа нь 2019 оны 02 сарын 17-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд үргэлжилнэ. Олон нийтийн идэвхтэй оролцоог хангахад та бүхний дэмжлэг ихээхэн чухал байна.

Судалгааны аппликэйшнийг танилцуулах плакат, тараах материал, хаалганы стикер зэргийг албан байгууллагын зохих газар байршуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, фейсбүүк, сошиал сувгуудаар сурталчлах ажил явагдаж байгаа хэдий ч судалгааг бөглөх идэвхи сул байна. Иймд та бүхэн өөрсдийн орон нутгийн хүрээнд 150-200 гаруй иргэдээр Tobacco Spotter аппликэйшнийг гар утаст нь татуулан судалгааг бөглүүлэхэд дэмжлэг үзүүлнэ үү.

Түүнчлэн шинжээчдийн өргөтгөсөн асуумж судалгаа дээрх судалгааны хугацаанд хамт явагдаж байгааг мэдэгдье. Үүнд Улаанбаатар хот ба орон нутгаас сонгогдсон 60 орчим мэргэжилтнээс асуумж судалгаа авах юм.

Энэхүү аппликэйшнийг бөглөх, сурталчилгааны ажлыг явуулахад Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зүгээс багахан төсвийн дэмжлэг үзүүлж байгаа ба орон нутагт зохион байгуулах ажлыг хариуцан ажиллах мэргэжилтний нэр, холбоо барих утас, э-майл хаяг, дансны дугаарыг 2019 оны 03 дугаар р сарын 01-ний дотор ubyambadorj@gmail.com, nyamka.drm@yahoo.com; naranchimegj4@gmail.com хаягаар ирүүлнэ үү.

Мөн сурталчилгааны ажлын гүйцэтгэлийн тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хавсралт загварын дагуу бөглөн ubyambadorj@gmail.com-90085500, nyamka.drm@yahoo.com-99082818; naranchimegj4@gmail.com- 95866349, 88866349, enkhtuya@ncmh.gov.mn-88084432 хаягаар тус тус ирүүлэхийг хүсье.

*Жич: Сурталчилгааны маркетингийн төлөвлөгөө, зардал, тайлан ирүүлэх хүснэгтийг хавсаргав.*

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л.НАСАНЦЭНГЭЛ

000000048

| | |
|---|---|
| Хугацаа | III.27-IV.30 |
| Уриа | Хуулийг “Tobacco Spotter”-оор үнэлье |
| Веб сайтууд | Facebook.com/TovchMN, Facebook.com/Монголдоо |
| Материалууд | 2 ТВ шторк (сурталчилгаа/заавар)<br>2 инфографик<br>18 зурагт хуудас (4 багц)<br>3 стикер<br>1 гарын авлага (Тамхидалтын эсрэг хувьсгал) |
| Live видео | 20-30 минут, 6 удаа |
| Зурган түүх/линк | Тамхигүй ажлын байрны бодлого хэрэгжүүлсэн |
| Лоттерей | Facebook-аар урамшуулалт давалгаа |
| Орон нутагт зохиосон үйл ажиллагаа | ТВ ярилцлага, сурталчилгаа, киноны өмнөх зар, зурагт хуудас наах, урсдаг зар |
| Арга хэмжээ | Явган аялал |

| | | 2 сар | 3 сар | | | | 4 сар | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Долоо хоног | | | | | | | | |
| | | III-IV | I | II | III | IV | I | II | III | IV |
| ТВ шторк | “Бэлэн үү Илрүүл Илгээ” сурталчилгаа-ны шторк | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | |
| | “Бэлэн үү Илрүүл Илгээ” заавар | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа-Ням |
| Инфо-график | Business case | | | | | | | | | |
| | Factsheet | | | | | | | | | |
| Зурагт хуудас | Багц 1 | Даваа -Ням | | | Даваа -Ням | | | | | Даваа-Мягмар |
| | Tobacco spotter 5&1 | | | | | | | | | |
| | Tobacco Free Revolution 3&1 | | | | | | | | | |
| | No to tobacco 1&4 | | | | | | | | | Лхагва-Пүрэв |
| | Багц 2 | | Даваа -Ням | | | | Даваа -Ням | | | |
| | Tobacco spotter 5&2 | | | | | | | | | |
| | Tobacco Free Revolution 3&2 | | | | | | | | | |
| | No to tobacco 2&5 | | | | | | | | | |
| | Багц 3 | | | Даваа -Ням | | | | Даваа -Ням | | Баасан |
| | Tobacco spotter 5&3 | | | | | | | | | |
| | Tobacco Free Revolution 3&4 | | | | | | | | | |
| | No to tobacco 3&6 | | | | | | | | | |
| | Багц 4 | | | | Даваа -Ням | | | | Даваа -Ням | Бямба-Ням |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Tobacco spotter 5&4 | | | | | | | | | |
| | Tobacco Free Revolution 3&5 | | | | | | | | | |
| | No to tobacco 8&7 | | | | | | | | | |
| Стикер | Tobacco spotter 1 | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа -Ням | Даваа-Ням |
| | Tobacco free revolution 1 | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | |
| | Tobacco free revolution 2 | | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа -Ням | | Даваа-Ням |
| Гарын авлага | Tobacco free revolution | | | | | | | | | |
| Live видео | N1 Төрийн байгууллага | | | | | | | | | |
| | N2 Их дээд сургууль | | | | | | | | | |
| | N3 ЕБС | | | | | | | | | |
| | N4 Эмнэлэг | | | | | | | | | |
| | N5 Ресторан | | | | | | | | | |
| | N6 Нийтийн тээвэр | | | | | | | | | |
| Зурган түүх/ линк | Зурган түүх | | | | | | | | | |
| | Линк | | | | | | | | | |
| Лоттерей: Хэн хамгийн сайн оролцогч вэ? | Эхний давалгаа: 3 сарын 08-ны өмнө | | | | | | | | | |
| | Хоёр дахь давалгаа: 4 сарын 01-ний өмнө | | | | | | | | | |
| Орон нутагт зохиосон үйл ажиллагаа | ТВ ярилцлага, сурталчилгаа, киноны өмнөх зар, зурагт хуудас наах, урсдаг зар | | | | | | | | | |
| Арга хэмжээ | Явган аялал зарлах | | | | | | | | | |
| | Үйл ажиллагааны зураг | | | | | | | | | |
| Мэдээлэл | Явцын мэдээлэл | | Ням | Ням | Ням | Ням | Ням | Ням | Ням | Ням |
| Бүүстинг хийх | Эхний | | | | | | | | | |
| | Дараагийн | | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 8:** Судлаачдын тэмдэглэл: Бодлогын баримт бичиг, туршлагын тайлбар

**Бодлогын баримт бичиг:**

Монгол Улсын Засгийн газар 2013 оноос эхлэн дотоод орчин тухайлбал, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, бага дунд сургууль, их дээд сургууль, коллеж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, ресторан, кафе, паб, баар, нийтийн тээвэрт тамхи татахыг хориглосон. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тамхины бүх төрлийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэлэгийг хориглох заалт хуулинд орсон. Тухайлбал зарлалын самбар, радио, телевиз, сонин, сэтгүүлээр тамхи, тамхин бүтээгдэхүүнийг сурталчилахыг бүрэн хориглосон.

***Тамхины хяналтын тухай хуулин дахь нэр томьёоны тайлбар:***

**“тамхин бүтээгдэхүүн”** гэж татах, үнэрлэх, зажлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн хэрэглээний бүтээгдэхүүнийг;

**“утаат тамхи”** гэж үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг;







**”дам тамхидалт”** гэж өөрийн хүсэл зоригоос үл хамааран бусдын татсан тамхины утаагаар амьсгалахыг;

**“тамхи үйлдвэрлэгч”** гэж тамхины үйлдвэрлэл, худалдаа, импортын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;

**“тамхины зар сурталчилгаа”** гэж тамхины үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээг дэмжихэд чиглэсэн аливаа хэлбэрийн мэдээлэл түгээх үйл ажиллагааг;

**“тамхины хяналт”** гэж тамхины хэрэглээ, тамхины утаанд нэрвэгдэх явдлыг бууруулах замаар хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах зорилго бүхий тамхины эрэлт хэрэгцээ, нийлүүлэлт болон хор хөнөөлт чанарыг бууруулахад чиглэсэн бодлогын цогц

**“тамхигүй орчин”** гэж тамхи татах, тамхины утааг харах, үнэрлэх, мэдрэх, хэмжих боломжгүй орчныг;

**“дотоод орчин”** гэж дээвэр, хана, талуудаар хүрээлэгдсэн орон зай (хийсэн материал, тухайн орон зайг түр хугацаанд буюу байнга ашиглахаас хамаарахгүй)-г;






**“брэнд өргөтгөх”** гэж тамхи, тамхин бүтээгдэхүүний нэр, барааны тэмдэг, лого зэрэг бусад ялгарах онцлогийг тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой мэтээр ашиглахыг;







**“брэнд хуваалцах”** гэж тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, барааны тэмдэг, лого зэрэг бусад ялгарах онцлогийг тамхи, тамхин бүтээгдэхүүн, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой мэтээр ашиглахыг.

**“утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэг”** гэж утаат тамхи татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан тасалгааг.

Тамхины хяналтын тухай хуулийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх нь” сэдэвт туршилт судалгаагаар байгууллагын дотор ажиглалт хийхдээ тамхи татаж байгаа хүн, тамхи татахыг хориглоно гэсэн тэмдэг байгаа эсэх
















Тамхины хяналтын тухай хуулийн зөрчлийг мэдээлэх хуудас, үнсний сав, тамхины иш байгаа эсэхэд ажиглалт хийсэн.







# НОМ ЗҮЙ


1. Монгол улсын өсвөр үе, насанд хүрэгчдийн тамхидалтын өнөөгийн байдлын Үндэсний судалгаа, 2017
2. НҮБ-ын төрөлжсөн агентлагын хамтарсан багийн Монгол улс дахь ТХСК-ийн хэрэгжилтэнд хийсэн үнэлгээ, 2015
3. Mongolian steps survey on the prevalence of non communicable disease risk factors 2009, 2013
4. Global tobacco surveillance system-Mongolia, 2013
5. Тамхины хяналтын тухай хууль, 2012
6. Сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тандах судалгааны ажлын тайлан, 2006
7. Архи, хар тамхи, мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бодист донтогсдын эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хууль эрх зүйн судалгааны тайлан, 2010
8. WHO, Tobacco or Health: A global status report, Geneva, 2001
9. Ministry of Health and Public Health, Knowledge, Attitude and Practice towards risk factors of Non communicable disease, Ulaanbaatar, 2002